

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР  
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-4
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл</b>	5-36
	1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-10
	2.“Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	10-11
	3.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газраас 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	11-36

## ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

***Гурав.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газраас 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга О.Цогтгэрэл, мөн яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Болортуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Газрын дарга Д.Цолмон, мэргэжилтэн Н.Жамъянхүү, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын хуульч Р.Лхагвабаяр, Хөтөч тайлбарлагчийн холбооны тэргүүн Ч.Буянбадрах нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ж.Бат-Эрдэнэ, С.Чинзориг, М.Оюунчимэг, Ч.Ундрам, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ж.Бат-Эрдэнэ, М.Оюунчимэг нар үг хэлэв.

**Ц.Цэрэнпунцаг:** Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

### ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэж эхэлье.**

Ажлын хэсгийг оруулаарай. Нямбаатар сайд байна уу, Засгийн газрын гишүүдээс байна уу.

Түвдэндорж дэд сайд хэн Нямбаатар сайд хаана байна. Ажлын хэсгийн 3 номерын чөлөөлөөд өг дөө. ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе. Хуулийн төслийг Улсын. Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулна.

**Х.Нямбаатар:** Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023, 2024, 2025 оныг Монголд зочлох жил болгон зарласан. Монголд зочлох жилийн бэлтгэлийг хангах, аялал жуулчлалын салбар дахь эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Монгол Улсын. Их Хурлаас 2000 онд батлагдсан аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах шаардлага бий болсон.

Монгол Улсын. Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 27-д аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулахаар тус тус заасны дагуу Алсын хараа 2050, 2020-24 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийн хүрээнд аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран боловсрууллаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Уг хуулийн төслийг дараах агуулгаар өргөжүүлэн шинэчилсэн.

1. Аялал жуулчлалыг эдийн засгийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд зориулах салбарын оролцогчдын эрх зүйн байдлыг сайжруулах зохицуулалтыг тусгалаа.

2. Аялал жуулчлалын салбарыг бие даасан санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр дэмжих зорилгоор аялал жуулчлалыг хөгжүүлэх сан бий болгох, уг сангийн удирдлагад хувийн хэвшлийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

3. Аялал жуулчлалын байгууллагын Тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж ангилан экспортын үйлдвэрлэл тооцох, татварын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зохицуулалтыг тусгалаа.

4. Аялал жуулчлалын худалдан авсан бараа бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн албан татварыг 100 хувь буцаан олгох эрх зүйн орчныг бүрдүүлэв.

5. Аялал жуулчлалын стратегийн ач холбогдол бүхий бүсийг зарлан бүсийн хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын ойлголтыг нэвтрүүлж, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэв.

7. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой тусгай зориулалтын зарим төрлийн ан агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар нээлттэй олгох эрх зүйн орчныг бүрдүүлэв.

8. Хууль хил орчмын аялал жуулчлалыг олон улсын тусгай зөвшөөрөлтэй тур оператор компаниар гүйцэтгүүлэх тусгай нөхцөлийг тодорхойлов.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар үндэсний онцлог бүхий үндэсний соёл, байгаль, түүх соёлын өвийг мэргэжлийн холбоод тухайн орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан аялал жуулчлалын үйлдвэрлэл болгон хөгжүүлснээр 2023 онд 1 сая, 2024 онд 1,6 сая жуулчин хүлээн авч дотоодын зах зээлд 2 тэрбум америк долларын эдийн засгийн эргэлтийг бий болгоно гэж үзэж байна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 5 бүлэг, 33 зүйлтэй бөгөөд Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг нийт 13 хуульд өөрчлөлт оруулах төслийг хамтад нь боловсруулаад байна.

Иймд Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайдад баярлалаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя.

Г.Түвдэндорж БОАЖЯ-ны дэд сайд, Цогтгэрэл БОАЖЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Б.Болортуяа БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга, Н.Цолмон ХЗДХЯ-ны газрын дарга, Жамъянхүү ХЗДХЯ-ны мэргэжилтэн, Р.Лхагвабаяр Монголын эрх зүй судалгаа хөгжлийн төв ТББ-ын хуульч.

Ингээд төсөлтэй хологдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Адьшаа гишүүнээр тасалъя.

Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Аялал жуулчлалын хууль нэн яаралтайгаар орж ирж байна. Тэгээд үүний шалтгаан нь юу юм бэ? Нэг асуулт байна.

2-т нь, бид нар ингээд энэ ерөнхий хууль маань аялал жуулчлалынхаа том зураглалыг яг яаж гаргасан юм бол оо. Аялал жуулчлал маань өөрөө бас дотроо олон хэсэгт хуваагддаг. Тэгээд Монгол Улсын аялал жуулчлалын нэгдүгээр зорилго нь юу юм, аль аялал жуулчлалаа илүү хөгжүүлэх юм, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ гээд бид олон жил ярьж байгаа. Энэ дээр бол мэдээж хилийн гадна талд байгаа нутаг нэгт Буриадууд, Өвөр Монголчууд, Монголд орж ирж тусгаар Монгол Улсын сүлдэт баганад мөргөж, цаашлаад уул овоондоо мөргөх, өвөг дээдсийнхээ шүтэж байсан уул усандаа мөргөх гээд ийм аялал жуулчлалын бас нэг хэлбэр байдаг. Тэгээд харамсалтай нь энэ өнөөдрийг хүртэл хөгжихгүйгээр ингээд яваад байгаа. Жишээлбэл, Рашаант гээд Хятадын аялал жуулчлалын том цогцолбор байдаг, түүний цаад талд жилдээ 3 сая жуулчин ирдэг гэж байгаа. Энэ дотор бас ирж байгаа жуулчдын тодорхой хувь нь Монгол руу орж, бас тусгаар Монгол Улсын хил дээр гарч ингэх бас хүсэл сонирхолтой байдаг юм байна лээ. Тэгээд үүнийг зохицуулдаг гол зохицуулалтууд нь болохоор мэдээж орж гарах тэр визний асуудлууд байдаг. Жишээлбэл тэнд Рашаант юм уу тэр Шилийн гол аймгийн Бичигт Хатавчийн боомт гэж байдаг. Түүний цаана байгаа Өвөр Монголын жуулчид маань орж ирэхийн тулд Хөх хот юм уу, Эрээн рүү орж ирж виз мэдүүлдэг. Энэ виз мэдүүлэх асуудал нь бол нэлээн цаг хугацаа ордог 2 ч үйлчилгээ. Бид нар ер нь энэ аялал жуулчлалынхаа хуультай бас дагалдуулаад бас гадаад харилцаа дээр анхаарч визний үйлчилгээгээ хил дээр олгох юм уу, нэг эсвэл бүс нутагт нь тодорхой бүс нутгууд дээр нэмж Монгол Улсын газар, тэр консулуудыг байгуулж виз олгох энэ боломжуудыг нээж өгч байж бид нарын өнөөдрийн зориод байгаа бас энэ жуулчдыг хүлээж авах ийм боломж нээгдэх байх гэж бодож байна. Энэ дээр бас тодорхой асуулт Нямбаатар сайд байгаа учраас асууя.

Энэ дээр шууд утгаар нь нөгөө богино хугацаатай визний асуудлыг зохион байгуулах боломж байгаа юу? Энэ хуулийг дагалдуулаад өнөөдөр аялал жуулчлалын жил болгож зарласны мөн чанар чинь хамгийн олон жуулчдыг яаж оруулж ирэх вэ гэдэг зорилтоо тавьж байгаа байх. Тэгээд дотоодын мэдээж аялал

жуулчлалын энд байна л даа, аялал жуулчлал маань өөрөө дагалдаад тэр бооцоот тоглоом, казиногийн хуулиуд орж ирвэл бид бүхний хувьд бол боловсон хүчний дутагдал маш өндөр гарна. Энэ хүмүүсээ бид нар ямар зохицуулалтуудаар Монгол Улсад ажиллуулах юм. Цаашлаад тэр хөрөнгө оруулалтынх нь асуудлууд дээр тодорхой асуудлыг ярихгүй бол өнөөдөр бид бүхэн ингээд гоё юм яриад байдаг, гарах үр дагаврын яг мөн чанаруудаа олж чадахгүйгээр бид нар олон асуудлууд дээр ингээд бүдэрч унаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бүр ингэж цогцоор нь яаж харж байгаа юм бэ гэдгийг бас асууя.

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайд хариулах уу? 3 номерын микрофоныг нээ дээ.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Ганибал гишүүний асуултад маш тодорхой хариулъя.

1 дүгээрт, яагаад яаралтай горимоор оруулж ирж байгаа юм бэ? Ердийн горимоор оруулж ирээгүй юм бэ гэхээр тэгээд Ерөнхий сайд ирэх жилийг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулж аялал жуулчлалынхаа тухай хууль, энэ салбарт гаднын аялал жуулчлалын компаниудад, аялагчдад ямар мессеж өгөх гэж байгаа юм бэ, тэр мессежээ энэ ондоо багтаж хуулиа батлаад энэ мессежийг өгмөөр байна гэдэг ийм зорилт тавьж байгаа.

Энэ хүрээнд бид нар энэ хуулийн товчоор нь базаад хэлэх юм бол хамгийн давуу талыг нь хэлээч ээ, юугаараа ялгарч, юугаараа аялал жуулчлалын тийм буум тарих гээд байгаа юм бэ, үүнийгээ хэлээч ээ гэж байна. Тэгэхээр ер нь судалгааны явцад аялал жуулчлал дээр 2 том зүйл байдаг юм байна. Нэг нь ямар нэгэн визгүй буюу визийн хөнгөлөлттэй байх нь тухайн улсыг зорьж ирэх нэгдүгээр сонирхол болдог юм байна. 2 дугаарт нь, тухайн улс руу очих тэр тээвэр хамгийн хямдхан байх нь хамгийн 2 дахь, тэр аялал жуулчлалыг ихэд татдаг түлхүүр зүйл байдаг юм байна.

Тийм учраас энэ Аялал жуулчлалын тухай хуулиар саяын 2 асуудлыг шийдэж байгаа. Та сая визтэй холбоотой асуудал ярьсан. Өнөөдөр бид нар дэлхийн бас нэлээдгүй олон орныг визгүй зорчуулах ийм 30 хоногийн визгүй зорчуулж байгаа. Энэ тоогоо өргөжүүлнэ ээ гэдэг бас амлалтыг энэ хуулийн дагуу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг хөндөж шийдэж байгаа.

Дээр нь үлдсэн бусад орнуудыг нь бүгдийг нь и-визтэй болгоё. И-визийг Ерөнхий сайдад бас хууль хэлэлцүүлгийн явцад санал болгосон, 48 цагийн дотор шийдэгддэг байя. Виз хүсэгч и-виз Монголиа гэдэг портал сайтад хандлаа, төлбөрөө төллөө, хүсэлтээ хийлээ, аксепт хийлээ, бараг тэр дор нь унадаг. Шаардлагатай, зарим тодруулга авах тохиолдолд хамгийн цаад тал нь 48 цаг байхаар тогтож байгаа юм.

2 дахь зүйл нь болохоор бид нар өнгөрсөн жил Солонгосын иргэдийг визгүй болгосон шүү дээ. Тэгээд түүний эффект энэ 7, 8 сард маш хүчтэй ажиглагдсан, тийм учраас бид нар Европ чиглэлийн бараг дийлэнх орнуудыг визгүй ангилал руу оруулахаар бас шийдэж байгаа. Үлдсэн орнуудыг нь и-визтэй болгоё, и-виз нь 48 цагийн дотор шийдэгдье, тариф нь бага байя гэж байгаа юм.

Онгоцны нислэгийн тийзийг аялал жуулчлалыг дэмжих сангаас татаас олгоё, агаарын тээврийн салбарт. Монгол руу ирж байгаа нислэг болгон дээр

татаас өгч тийзээ хямдруулъя, дотоодын нислэгийг бас дэмжиж тийз дээр нь татаас олгоё гэдэг ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа.

Би зүгээр нэг мэдээлэл хэн Ганибал гишүүн аваагүй байна уу гэж бодлоо. Хил орчмын аялал жуулчлалыг дэмжье гээд бид нар жил гаруйн өмнө та бид бүгд баталсан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад хил орчмын иргэдийг бүлэг жуулчдыг 72 цагийн дотор визгүй болгочихсон. Өөрөөр хэлбэл таны яг ярьж байгаа Рашаан хотод жилд 5 сая жуулчин ирдэг юм байна лээ, цаанаа, гүнээсээ, өмнө орноосоо. Тэр жуулчдаас бид нар Хэнтий, Дорнод, Сүхбаатарын тэр хил орчмын аялал жуулчлалыг хүлээж авах Тур агентлаг нь хамгийн багадаа нэг, ядаж 5, 10 хувийг нь авахад л бид нар 500-250000 жуулчин авна л гэсэн ийм том тоо байгаа. Тэгэхээр визний нөхцөл дээр хил орчим дээр бол тийм өөрчлөлтийг оруулсан.

Хилийн аялал жуулчлал гэж юуг хэлж байна вэ гэвэл Монгол төрийн сүлдэт багана дээр очих аялал жуулчлалын тусгай маршрутуудыг бид нар бий болгож өгье өө. Түүнийгээ хил хамгаалах байгууллага болон бусад аялал жуулчлалын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, аюулгүй байдал, хил хамгаалалтын тэр дүрэм журамтай нийцүүлж явуулдаг болъё.

Дотоодын аялал жуулчлал ч гэсэн хилийнхээ баганад очиж мөргөдөг ийм аялал жуулчлалын маршрутыг бий болгоё гэдэг ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа юм.

Эцэст нь энэ Аялал жуулчлалын тухай хуулийн нэг бас 1 онцлог нь бол бид нар ирсэн жуулчдыг аюулгүй ирүүлээд, аюулгүй жуулчлуулаад, аюулгүй буцаах гэдэг ийм концепц руу явж байгаа юм. Жишээлбэл, Мальдивын аялал жуулчлалын тухай хуулийн гол үндсэн агуулга бол аюулгүй ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайд сүүлийн дараагийн хариулт дээрээ гүйцээгээд хариулчхаарай.

Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Аялал жуулчлалын тухай хууль орж ирж байна, зөв дэмжиж байгаа. Ер нь аялал жуулчлалынхаа энэ салбарыг нэлээн өргөнө гээд бид нар бас олон жил ярилаа. Нэг сая жуулчны асуудал ярьсаар байгаад хэдэн ч жил өнгөрөв 300, 400000-аас дээшээ гарсангүй.

Тэгэхээр аялал жуулчлал хөгжих хамгийн гол хаалга бол энэ тээврийн асуудал шүү дээ. Сая Нямбаатар сайдын асуудал дотор орж ирж байна, 1 дүгээрт, визтэй холбоотой асуудал. 2 дугаарт тээвэртэй холбоотой асуудал, тийм үү, тээвэртэй холбоотой асуудал. Бид энэ тээврийнхээ асуудлуудыг нээх ёстой. Агаарын тээвэрлэгчдээ дэмжих ёстой, хамгийн бага үнийг боломжит хамгийн бага шүү, үнийг бид нар санал болгох ёстой байхгүй юу даа. Ингэж байж энэ аялал жуулчлал чинь наашаа урсгал нь бол нэмэгдэх ёстой.

Тэгээд 2 дахь асуудал хүрч ирээд, юу үзэх вэ гэдэг бол дараагийн асуудал болж байгаа байхгүй юу даа. Тэгэхээр энэ тээвэртэй холбоотой асуудлуудыг хэрхэн яаж дэмжих юм бэ? МИАТ-тай холбоотой асуудал одоо бид нар ердөө үндэсний иргэний агаарын тээврийн үндэсний тээвэрлэгч эд нар гээд МИАТ-аа бол дахин шүтчихээд байгаа шүү дээ. Мэдээж МИАТ-ын дотоод үйл ажиллагаа бол

хүнд байгаа. Гэхдээ сая жуулчин авах хэмжээний боломжийг бид нар энэ МИАТ-аараа нээх ёстой байхгүй юу даа. Тэгээд буцаад эргээд цаагуураа МИАТ компаниа дэмжих ийм боломж бололцоог бол харах ёстой байх. Үүнийг л яриад байх шиг байна, тэгэхээр яаж дэмжих юм бэ гэдэг асуудлуудыг нэг жоохон тодруулж өгөөч.

Үүнээс гадна зөвхөн МИАТ биш шүү дээ. Энэ чинь дотоодын тээвэрлэгч өчнөөн компаниуд байж байна.

2 дугаарт, аялал жуулчлалыг хөгжүүлэх сан гээд бид нар нэг сан байгуулаад энэ сангийнхаа хөрөнгийг бас нэлээн яаш хааш, ийш нь тийш нь татаж чангаагаад, зарцуулалтаа буруу аваад явчихдаг. 1 дүгээрт, аялал жуулчлалын сан маань яг ямар хөрөнгийн эх үүсвэрээс бүрдэх юм бэ, төсвөөс орох юм уу, эсвэл хураамж илүү дутуу юмнуудаасаа юу яах юм уу, хэрхэн яаж аялал жуулчлалыг хөгжүүлэх сан маань бий болох юм бэ? 1 дүгээрт.

2 дугаарт, үүнээсээ саяын миний ярьсан тээвэр ложистиктой холбоотой асуудлуудаа яах юм.

3 дугаарт сангаа өшөө юу юунд зарцуулах юм бэ, үүнийг тодруулж өгөөч. Нэлээн хэдэн зүйлүүд заалт байх шиг байна. Гэхдээ энэ чинь тодорхой биш л харагдаад байна л даа. Аялал жуулчдынхаа үздэг, хардаг зүйлээдээ, магадгүй зүгээр энэ өөр компаниудаа дэмжих, үзэж хардаг зүйлүүдээ дэмжих, үзмэрүүдээ сайжруулах ч гэдэг юм уу мэдэхгүй одоо ямар зүйлүүд байх ёстой юм. Тэр зүйлийг нь тодруулж өгөөч гэж. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе дээ.

**Х.Нямбаатар:** Бат-Эрдэнэ сайд бас яг энэ салбарын сайд байсан хүний хувьд энэ салбарын зовлон жаргалыг хамгийн сайн мэдэж хүний нэг ээ. Ерөнхий сайд ямар бодлого баримталж энэ хуулийн төсөлд саналаа өгсөн бэ гэхээр Монгол руу ирэх гэж байгаа нислэгийн тоо давтамжийг хязгаарлахгүй байя аа, энэ бол агаарын тээврийг либералчилъя хамгийн том, эхний том алхам гэж ойлгож байгаа. Тодорхой жил заасан, та бүхэн сая танилцуулга дээр сонссон. 2023, 24, 25 он. Энэ бол Монголд зочлох жил. Аялал жуулчлалын салбарыг дэмжих жил. Аялал жуулчлалын салбар өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувийг үйлдвэрлэж байгаа бол түүнийг 3, 4 дахин, 5 дахин өсгөнө гэсэн ийм том зорилтыг дэвшүүлж энэ хуулийн төслийг боловсруулж байгаа.

Ингэхдээ агаарын тээврийн салбарт либералчилъя гэвэл Монгол руу нисэж байгаа нислэгийн тоо давтамжийг хязгаарлахгүй байх энэ бодлогыг 1 дүгээрт барья.

2 дугаарт, авчирсан тээвэрлэж ирсэн зорчигчийнх нь тоогоор татаас дэмжлэгийг үзүүлэх тогтолцоо руу шилжье гэсэн ийм агуулгаар орж ирж байгаа.

Үүнийг хаанаас санхүүжүүлэх вэ гэхээр аялал жуулчлалыг дэмжих хөгжүүлэх сангаас санхүүжүүлъя гэж байгаа. Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь дараах орлогоос орлого нь бүрдэх юм.

1 дүгээрт, казиногийн тэр онцгой албан татварын 5 хувь, морин бооцоот уралдааны орлогын албан татварын 5 хувь, иргэний нисэхийн тухай хуульд заасан аялал жуулчлалын навигацийн үйлчилгээний орлогын 20 хувиас энэ юуг төвлөрүүлбэ гэж байгаа юм.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн зөвшөөрлийн хураамжийн орлого зэргээс энэ аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн орлого бүрдбэ.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан дараах 4 төрөлд мөнгөө зарцуулъя.

1 нь, саяын нөгөө агаараар зорчигч тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,

2-т нь, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах шинэ аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэхэд ,

3-т нь, гадаад, дотоодод Монгол Улсыг сурталчлах үйл ажиллагаанд,

4-т нь, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхэд гэсэн ийм 4 зориулалтаар аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн мөнгийг зарцуулъя. Үүний хамгийн 1 дүгээрт, агаараар зорчигч тээвэрлэхэд дэмжлэг үзүүлбэ гэсэн ийм зориулалтаар аялал жуулчлалыг дэмжих сан байя гэж байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. 1 минут.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зам, тээврийн сайд байхдаа наад либералчлалыг чинь Иргэний агаарын тээврийн либералчлалыг эхлүүлсэн. Сөүлийн чиглэлийн билетийг 30-35 хувь буулгасан, либералчлалын үр дүнд. Одоо би юу асуух гээд байна гэхээр одоо энэ шинэ хуулийнхаа концепц, шинэ хуулийнхаа хүрээнд билетийн үнэ хэдэн хувиар буурна гэж та бүхэн тооцож байгаа вэ. Мэдээж наашаа нислэгийн тоог нэмэгдүүлэх байх. Нислэгийн тоо нэмэгдэхээс гадна үнийн чинь асуудал буух ёстой шүү дээ. Сая бид нар ярьсан тийм үү. Хэдэн хувь бууя гэж тооцож байгаа юм, 1 дүгээрт.

2 дугаарт сан маань ер нь барагцаагаар хэдэн төгрөг энд хуримтлагдах вэ. Саяын ярьсан казиногийн орлого, саяын ярьсан тэр юутай холбоотой иргэний нисэхийн татаас түүнээс авъя энэ тэр гэсэн хэд хэдэн зүйл ярих шиг боллоо. Ер нь барагцаагаар хэд хуримтлал бич болох юм бэ. Энэ маань ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Бат-Эрдэнэ гишүүн 2 тодорхой асуулт асуулаа тийм ээ. 3 номер хариулах уу. 3 номерын микрофоныг нээе. Нямбаатар сайдын микрофоныг нээе.

**Х.Нямбаатар:** Хууль мэдээж хэрэг батлагдахдаа техник эдийн засгийн тооцоолол хийдэг л дээ. Бид нар энэ 2019 оны статистик дээр тулгуурлаад ирэх 2023 онд бид нар 1 сая жуулчин хүлээж авъя гэсэн агуулгаар. 2024 онд 1,6 сая жуулчин хүртэл жуулчдынхаа тоог нэмэгдүүлнэ гэж үзэхэд манай улсад 2 тэрбум орчим америк долларын аялал жуулчлалын салбарын бараа бүтээгдэхүүн борлуулагдана гэдэг тооцоолол гарсан.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх санд хэдэн төгрөг төвлөрөх вэ гэдгийг яг өнөөдөр бид нар урьдчилан тооцох боломж хэцүү байгаа. Яагаад гэвэл бид нар шинэ төрлийн татваруудыг шинэ хуулиа батлагдаж байж шинэ төрлийн татваруудыг ноогдуулах гэж байгаа юм. Тухайлах юм бол Казиногийн хуулийг бид нар маргаашийн Засгийн газрын хуралдаан дээр нэмэлт асуудал болгож оруулах гэж байгаа. Морин бооцоот уралдааны хууль, төлбөр тааварт тоглоомын хууль. Казиног ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Нэмэлт хариултын нэмэлт хугацаа өгье. 3 номер дээр микрофон дээр.

**Х.Нямбаатар:** Казиногийн хууль дээр орлогын 40 хувийг казиногийн татвар болгож улс хурааж авъя өдөр болгон. Юун дээр морин бооцоот уралдаан дээр 70 хувь татвар нь, юун дээр төлбөр тааварт тоглоомын хууль дээр 20 хувь өгсөн байгаа. Эдгээрээс тодорхой орлогууд орно. Илэрхий бид нарт мэдэгдэж байгаа зүйл бол навигацийн орлогын энэ 20 хувь гэдэг бол энэ бол тогтмол улсын төсөв дээр бичигдэж байгаа тооны 20 хувь очно гэж байгаа юм.

Дараагийнх нь нэг юм бол агаарын тээврийн үнэ хэд байх вэ гэдгийг бол одоо урьдчилж хэлэхэд хэцүү, энэ бол зах зээлийнхээ замаар өрсөлдөөнийхөө зарчмаар үнэ тогтох болов уу гэж бодож байгаа. Сая энэ 8 сард гэхэд Сөүл Улаанбаатарын нэг талын нислэг чинь бүр хэдэн доллар болчихсон байлаа, 300 доллар болчихсон байх жишээтэй байсан. Тэгэхээр энэ бол цаашид ингээд өрсөлдөөн бий болох тусам энэ үнэ цаашаагаа бууна л гэсэн. Тэгээд хамгийн хямд үнээр ямар ч визийн нөхцөлгүйгээр ирдэг байх нь Монгол Улсын аялал жуулчлалын хамгийн нэг хөшүүрэг байх болов уу л гэж бодож байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Чинзориг гишүүн асуулт асууя.

**С.Чинзориг:** 2, 3 зүйл тодруулъя. Аялал жуулчлалын салбар чинь өөрөө бизнесийн бизнес л дээ. Би бол тэгж ойлгоод байгаа, бизнес биз дээ, бизнесийн салбар. Гэхдээ яах вэ, манайх улирлын шинж чанартай учраас бас гаднаас ирж байгаа жуулчдын тоог нэмэгдүүлэх энэ тэр гээд асуудал байгаа л байх. Тэгэхдээ энэ хуулийг чинь харахаар Нямбаатар сайд аа, ирж байгаа жуулчдад бид нар яг юу үзүүлэх гээд байгаа юм бэ гэдэг юм чинь ерөөсөө л хэлэгдэхгүй л байгаа юм. Би өчигдөр бас бүлэг дээрээ яриад л байсан. Аялал жуулчлалын үйлчилгээнд дараах үйлчилгээ гээд хоол үйлдвэрлэл, зар сурталчилгаа, урлаг соёл, худалдаа, гар урлалын бүтээгдэхүүн гээд байгаа юм. Эд нарыг л авахын тулд аялал жуулчин ирэхгүй биз дээ. Энэ Монголын чинь энэ ариун дагшин, энэ онгон байгалийг чинь үзэх гээд тэр түүх соёлын чинь юмыг үзэх гэж, энэ нүүдлийн аж ахуй эрхэлдэг уламжлалт энэ зан заншил, уламжлалыг чинь, соёлын чинь ёс зан, соёл заншлыг чинь үзэх гэж сонирхож ирнэ шүү дээ. Тэгээд яг юу үзүүлэх юм бэ гэдэг юмаа ерөөсөө хэлэхгүй, та бүхэн. Аялал жуулчлалын үйлчилгээнд ийм юм багтана гээд буудал, гар урлалын бүтээгдэхүүн, хоол гээд байгаа юм. Буудалд хонох гэж, нэг хоол идэх гээд гар урлалын бүтээгдэхүүн авах гэж аялал жуулчлал ирэхгүй юм байгаа биз дээ. Жуулчдад бид нар яг юу үзүүлэх юм бэ, юугаар үйлчлэх юм бэ гэдгээ тэр концепт чинь ерөөсөө энэ хуульдаа гаргаж өгөхгүй юм уу, хэлэхгүй юм уу.

Та бүхэн тэр тавдугаар зүйлээ хараарай л даа, үйлчилгээ хийнэ гээд байгаа юм, тэгээд л буудал, хоол, гар урлалын бүтээгдэхүүн үзүүлнэ гээд байгаа юм. Үүнийг чинь үзэх гэж ирэхгүй шүү дээ, одоо тэр Монгол ахуй, ёс, зан заншлыг чинь

үзэх гэж, энэ нүүдлийн МАА эрхэлж амьдардаг Монголчуудын чинь аж байдлыг үзэх гэж, энэ ариун дагшин байгалийг чинь үзэх гэж, түүх соёлыг чинь үзэх гэж түүхийн ховор олдвор юмыг чинь үзэх гэж л ирж байгаа шүү дээ. Яг ийм юмнууд үзүүлнэ ээ гэсэн юм байхгүй. Аялал жуулчлалын үйлчилгээ нь ийм байна гээд байр, хоол, буудал гээд хэлчихээр чинь хэн ирэх юм бэ, гаднынхан ирэх юм уу, үгүй юм уу. Үүнийг яг юу гэж ойлгоод байгаа юм. Үгүй бол би буруу ойлгоод байгаа юм болов уу.

2 дахь асуудал нь сантай болох юм байна. Тэгээд казиногийн хууль орж ирээгүй байна, тэр казиногийн орлогын 5 хувь, морин бооцооноос орох орлогын 70 хувийг сандаа бүрдүүлнэ гээд байдаг. Тэгээд тэр хуулиуд ч орж ирээгүй байх юм, Нямбаатар сайд аа. Тэгээд бид нар тэрийг чинь байгаа юм шиг ингээд орлого гэж яриад байх нь хэр оновчтой, яах юм, тэгээд хуулиуд чинь орж ирээгүй учраас тэгээд тэр казино хэзээ орж ирэх юм, батлагдах ч юм уу, үгүй ч юм уу, тийм морин бооцоотой хууль чинь хэзээ орж ирэх юм, батлагдах ч юм уу, үгүй ч юм уу. Тэгээд орж ирээгүй, батлагдаагүй хуулиудыг чинь бид нар орлогыг нь ингээд авна гээд ингээд сан гээд яриад байгаа юм.

Энэ сая Бат-Эрдэнэ гишүүн ч асуугаад л байх юм. Тэрийгээ сайн тодруулмаар байна. Агаараар аялал жуулчлагчийг тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм. Тэгээд энэ чинь тэд дотоодын нислэгүүдэд дэмжлэг үзүүлэх асуудал яриад байгаа юм уу? Үгүй бол өөрийн үндэсний авиа компаниар гаднаас ирж байгаа жуулчид ирж байгаа бол гаднаас ирж байгаа жуулчдыг ч гэсэн тэр тээвэрт нь дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм уу гэдгээ сайн ялгаж салгамаар байна шүү дээ. Дотоодын нислэгт дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм уу? Тэгээд сүүлд нь тэгээд энэ чинь ойлгомжгүй юм яваад тэгээд ойлгомжгүй байдал руу орно шүү дээ. Би бол дотоодын нислэг л гэж ойлгох гээд байгаа шүү дээ. Тэр нь зөв үү, тэрийгээ сайн тодорхойлж болохгүй юм уу?

Ер нь тэгээд цаашдаа энэ манай иргэний нисэхийнхэн энэ мэргэжлийн хүн Бат-Эрдэнэ мэдэж байгаа даа. Иргэний нисэхийн эртүүд ярьж байхад энэ олон улсын нөхцөл байдлаас ч юм болоод навигацийн орлого 50 хувиар буурчхаж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгээд бид нар навигацийн орлогын 20 хувийг нь сандаа авна л гээд байх юм. Тэгээд сүүлдээ энэ чинь нөгөө төсөвтөө ямар сөрөг нөлөө үзүүлэх юм, яах юм тэрийг нь тооцсон юм уу ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Чинзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

**С.Чинзориг:** Тэгээд та бүхэнд тэр навигацийн орлого нь цаашдын ямар хэмжээнд байна тооцож байгаа юм, 20 хувь гэхээр ямар хэмжээний орлого байх юм? Тэгээд тэр агаараар аялал жуулчлагчдыг тээвэрлэж байгаа бол ямар дэмжлэг үзүүлнэ гээд байгаа юм. Тэр нь дотоодынх юм уу, аль нь гэдгийг сайн тодорхой тайлбарлаж хэлээч.

Сая Нямбаатар сайд ярилаа, энэ жуулчлагчдад аюулгүй байдал маш чухал гээд. Тэгээд аюулгүй байдлыг чинь энэ яам хариуцах юм уу, жуулчдын аюулгүй байдлын яам хариуцна гэж ямар юм байдаг юм? Аялал жуулчлагч нар, жуулчдын аюулгүй байдлыг байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна гээд. Тэгээд тэр уул нь аялж яваа, амрагч, аялал жуулчлагчийн аюулгүй байдлыг яам хариуцах юм уу. Тэр орон нутаг нь хариуцахгүй юм уу. Цагдаагийн байгууллага нь хариуцахгүй юм уу. Яахаараа тэр хөдөө амарч байгаа, аялж яваа жуулчдыг нь төрийн захиргааны төр байгууллага

хариуцна гээд байдаг юм, би буруу ойлгоод байгаа юм уу? гэх мэтчилэн ингээд яриад байвал зөндөө юм байх юм. Тэгээд та нар нэг хариулт өгөөч.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Чинзориг гишүүний асуултад хариулъя. Юуны тэр агаарын тээвэртэй холбоотой дэмжлэг дээр бол гадаад, дотоодын бүх нислэг дээр дэмжлэг үзүүлэе ээ гэдэг ийм зарчмаар ажлын хэсэг дээр ярьсан. Гол нь нөгөө суулгаж ирсэн хүнийх нь тоогоор дэмжлэг үзүүлдэг тогтолцоо руу явъя. Тэр нь илүү бодитой, өөрөөр хэлбэл, манайд орж ирж байгаа аялал жуулчлалын тэр хүнээ тоолох, тооцох систем нь илүү тодорхой байна гэж үзэж байгаа. Энэ утгаараа агаарын тээвэрт дотоодын болон Монгол руу ирж байгаа олон улсын нислэг бүрийн зорчигчийн тоогоор дэмжлэг үзүүлэх ийм схем үйлчилгээ гэж байгаа юм.

Сая Чинзориг гишүүн бас үгээ эхлэхдээ ч хэлсэн, энэ чинь хувийн бизнес биз дээ гэдэг агуулгаар хэлж байх шиг байна лээ. Ер нь бол тодорхой салбарыг төр бодлогоор дэмжиж гаргаж ирдэг нь тэр тухайн улс орнуудын хөгжүүлсэн салбаруудын үндсэн хөгжлийн чиг хандлага гэж үзэж байгаа. Үүнийг бас судалгаан дээр суурилж хийсэн.

Юу үзүүлэх вэ гэж байна. Одоогоор манайд ирж байгаа аялал жуулчлалын 24 хувь нь нүүдэлчин ахуй, соёл үзэх гэж ирж байгаа, 34 хувь нь байгаль үзэх гэж ирж байгаа, 12 хувь нь адал явдалтай аялал жуулчлал хийх гэж ирдэг, 10 хувь нь Монголын түүх, 11 хувь нь ан гөрөө, бусад нь ингээд бусад гэдэг ийм агуулгаар явж байгаа. Тэгэхээр Чинзориг гишүүн ийм байгаа, нөгөө Тур операторууд бид нарын төрийн үндсэн үүрэг бол тухайн улсдаа ирэх тэр хамгийн боломжийг л нээж өгөх ёстой. Тусгай зөвшөөрөл авсан Тур операторууд бүтээгдэхүүнээ яаж баяжуулж, тэр ирсэн жуулчдаас яаж нэмүү өртөг шингээх вэ гэдэг тэр бүх зүйл дээр нь төр дэмжлэг үзүүлж, орон нутагт дэмжлэг үзүүлж өгье өө л гэж байгаа юм. Тэгээд өнөөдөр манай нийт музейн үзмэрүүдийн бараг 60, 70 хувь нь складанд байна гэдэг бол бид нарын нөгөө энэ нөгөө бүтээгдэхүүнээ бид нар хөгжүүлж чадаагүйтэй л холбоотой.

Аюулгүй байдал талд таны асууж байгааг бол тэр тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжүүдийг хариуцгаажуулъя. Өөрийнхөө аялах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн цагдаагийн байгууллагатай гэрээ хийж, аюулгүй байдлыг нь сахин хангах, гэрээт харуул хамгаалалтаар хангах энэ мэтийг тэр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг үүрэг дээр нь ноогдуулж өгье өө, тэр утгаараа аюулгүй байдлыг хариуцна гэж үзэж байгаа.

Нөгөө хуулиуд нь Чинзориг гишүүн, үүнийг ер нь бол хэлэлцэх эсэхээ шийдвэл нөгөө хуулиудыг бас энэ 7 хоногтоо хамтад нь өргөн мэдүүлээд яаралтай горимоор явуулаад ингээд хамтад нь хэлэлцээд явъя л гэсэн ийм агуулгатай байгаа. Тийм учраас аялал жуулчлалын багц хууль гэж Засгийн газрын хуралдаан дээр бид томьёол оо гэж ярьсан.

Үзүүлэх үйлчилгээний хувьд бол бид нар тэр, ер нь Турк гэх мэт энэ аялал жуулчлалыг хөгжүүлсэн орнууд бол тэгж ярьдаг л юм байна лээ. Эхлээд л хоол хүнснээсээ эхлээд жуулчдыг татдаг ийм стандарттай болж байж, жуулчид Монгол оронд ирэх, дахин давтан ирэх, ирсэн хүмүүс нь дараагийнхаа сурталчилгаа, юмыг хийж явдаг л юм байна лээ. Тэгэхээр тэр саяын таны хэлдэг аялал жуулчлалын

тавдугаар зүйл дээр байгаа юм бол стандарт зүйлүүд. ЗГ 12 эвентийг Монгол Улсад зочлох энэ жилийн хүрээнд төрийн бодлогоор дэмжиж өгнө гэж байгаа юм. Жил болгон нэг эвент, сар болгон. Жишээлэхэд 7 сар бол наадам гэдэг эвент байх ёстой. 1 дүгээр сар юу гэдэг юм, мэргэжлийн тулааны урлагийн том тэмцээнийг зохион байгуул ч гэдэг юм уу, ийм байдлаар үзүүлэх юман дээр ЗГ 12 эвентийг дэмжиж өгье. Үүнээс гадна онцлог бүхий 84 эвентийг олон улсад сурталчилж өгье өө гэдэг бас ийм зүйлийг аялал жуулчлалын яам, Соёлын яамтай ярилцаж тохирсон гэдгийг хэлье.

**Ц.Цэрэнпунцаг:** Чинзориг гишүүн тодруулж асууя.

**С.Чинзориг:** Манай улс чинь их л баян болж байгаа юм байна даа. Гадаадын авиа компаниудад бас санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм яриад явчихлаа шүү дээ, Нямбаатар сайд аа. Би тэгж л ойлголоо шүү дээ, таны үгнээс. Тийм байж болох юм уу? Гадаадын авиа компаниар жуулчид ирсэн бол санхүүгийн дэмжлэг үзүүлнэ ээ гэж наад чинь их л халих нь дээ. Би бол дотоодын нислэг байвал яадаг юм бэ гэж бодож байгаа юм. Наад навигацийн чинь мөнгө тийм ч их мөнгө байхгүй шүү дээ. 100-аад тэрбум л цугладаг биз дээ, Бат-Эрдэнэ сайд. 100 гаруй, 100 орчим тэрбум төгрөг л цугладаг шүү дээ. Тэгээд тэрийг нь тэгээд дотоодын нислэгүүд, манайх ихэнх нь энэ манай МИАТ нь онгоцнууд явж чадахгүй, тэгээд л гадаадын хэдэн авиа компанийг л тэтгээд л, тэгээд л нэг нөгөө тэмээн дээр ямааны гарз гээч л юм үлдэх вий дээ? Ийм сонин юмнууд ярьдаг би бол гайхаад л байна, ойлгохгүй байна. Гадаадын авиа компани санхүүгийн дэмж .../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Сая Чинзориг гишүүн ерөнхийдөө саналаа хэллээ. Ингээд Оюунчимэг гишүүн. Тодруулж нэмэлт нэмж хариулах уу, ажлын хэсгээс. Ажлын хэсгийн 3 номерыг нээчихье дээ, нэмж хариулья 1 минут.

**Х.Нямбаатар:** Яах вэ, Чинзориг гишүүн дандаа нөгөө юмыг хэдүүлээ болохгүй талаас нь яриад л байвал болохгүй л дээ. Өмнө нь тэгээд энэ аялал жуулчлалыг хэдүүлээ, сая Бат-Эрдэнэ гишүүн ч хэлж байна лээ, сая жуулчин хүлээж авна гээд л зөндөө л ярьцгаасан. Бид нар тэгээд их бусад улс орнууд яаж энэ аялал жуулчлалаа нэмэгдүүлсэн юм бэ гэдгийг судалж үзээд хоёрхон л шийдэл байгаа шүү дээ. Ирж байгаа нислэгийн тоо, давтамжийг хязгаарлахаа болиод зах зээлийнх нь үнэ тогтоод, өрсөлдөөнөөр үнэ тогтоод, тэгээд түүн дээр нь зорчигчийнхоо тоогоор урамшуулал өгдөг тогтолцоо бүх газар л байна шүү дээ. Манай энэ хойд талын Манжуурт хүртэл ирж байгаа нислэгийн авиа компаниудад зорчигчийнх нь тоогоор дэмжлэг үзүүлдэг, тэр аялал жуулчлалынх нь сангаас мөнгө өгдөг тогтолцоо байна шүү дээ. Манай авиа компаниуд ч гэсэн дэмжлэг үзүүлж байгаа шүү дээ. Тэгээд бид нар яахаараа гаднын авиа компаниуд газрын шалан дээр нь унатал үнээ буулгаад, тэгээд өрсөлдөөн үүсгээд манайх руу ирж байгаа зорчигчийнх нь тоогоор бид нар тодорхой дэмжлэгүүд .../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ер нь бол яах вэ, зүгээр сангийн тал дээр бол эх үүсвэр нь яах юм бэ гэдэг дээр л бас манай гишүүд нэлээн санаа зовж байх шиг байна. Ер нь эхлээд бол шууд эхэлнэ, нөгөө 2, 3, 5, 5 хувийн татвар авна гэж байгаа бооцоот уралдаан, казино эд нараас чинь хуримтлал цуглаж байтал бас хугацаа орно, энэ хугацаанд янз бүрийн төсвийн дэмжлэг их шаардлагатай болох болов уу, үгүй болов уу л гэж анхаарч бас нэлээн асууж байх шиг байна, гишүүд маань.

Ингээд Оюунчимэг гишүүний микрофоныг нээе, асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Аялал жуулчлалын тухай хууль бол манайд бас хэрэгжээд нэлээд удаж байгаа. Харин энэ удаад бол шинэчилсэн найруулгаар, ер нь тэгээд л цогцоор нь нэлээд өөр түвшинд оруулъя гэж шинэчилж, найруулж оруулж ирж байгаа юм байна л даа. Үүнийг бол дэмжиж байгаа. Энэ бол бас чухал, бид нар ганц уул уурхай биш, хөдөө аж ахуй, аялал жуулчлал гээд энэ эдийн засаг, орлого олдог салбаруудаа төрөлжүүлэх тал дээр анхаарч байгаа. Тиймээс Их Хурал ч энэ дээр бол нэгдмэл байр суурьтай байгаа.

Харин энэ хууль хэрэгждэг байх ёстой, тэгээд яг тэр шинэчлэлийг нь хийх ёстой, тэгэхээр нухацтай хандах ёстой гээд гишүүдийн яриад байгаатай бол би ч гэсэн санал нэг байгаа. Би бас өмнө нь хэлж байсан, жишээ нь өмнө Энхбаяр Ерөнхий сайдын үед аялал жуулчлалыг үнэхээр өөр түвшинд гаргая гээд өвлийн аялал жуулчлал хөгжүүлбэ, яг аялал жуулчлалын чиглэлээр үнэхээр стандартын тоног төхөөрөмж оруулж ирье гээд гаалийг тэглэхэд тэр үед тоног төхөөрөмжийн шинэчлэл явагдаад нэлээд нааштай болж байсан. Батболд Ерөнхий сайдын үед нөгөө эдийн засгийн 17 хувийн өсөлтийг бид түшиглээд уул уурхай, түшиглээд аялал жуулчлалыг хөгжүүлэх олон улсын сүлжээ буудлууд, тухайлбал Кемпински, Шангри ла-г оруулж ирсэн, олон улсын сүлжээ хоолны газрууд дагаж орж ирсэн. Энэ өөрөө бас жуулчдыг татах Монгол гэдэг чинь өвөрмөц онцлог, сонирхолтой орноос гадна бас тэнд олон улсын сүлжээ нь байдаг юм байна гээд тийм ээ. Энэ ч гэсэн тухайн жуулчлалын тоог нэмэхэд бол нөлөө үзүүлсэн. Харин одоо жишээ нь Оюун-Эрдэнийн Засгийн газрын аялал жуулчлалын хуулийг шинэчлэн найруулж, цогцоор нь шийдэж байгаагийн сүүлд нь үлдэх хамгийн гол зорилго топ нь юу байх вэ гэдгээ бид бас тодорхойлох нь чухал байгаа юм.

Мэдээж казино тэр бооцоот тоглоомын хуулийг гаргаад үүнийг Монголд хөгжүүлбэ гэдэг дээр хүмүүс ч гэсэн бас цаг нь болсон гэсэн байр суурь байгаа нь бол харагдаж байна л даа. Харин үүнийг хийхдээ аялал жуулчлалын сангаас хийнэ гээд байгаа юм. Тэгэхээр Монгол, Макао 2 чинь өөр. Макаогийн хэмжээнд хүртэл Лас Вегасын хэмжээнд хүртэл бидэнд бол наад зах нь нэг 5, 10 жил хэрэгтэй. Тэгэхээр энэ санг юунаас яаж бүрдүүлэх вэ гэдэг өөрөө чухал шүү дээ. Тиймээс бид нар энэ хууль дээрээ маш тодорхой заалтууд оруулж өгье. Энэ сан юу юунаас бүрдэх юм, төсвөөс хэдэн хувь нь байх юм, гаднын зээл тусламж авах юм уу, эсвэл гадаадын шууд хөрөнгө оруулалт, нөгөө Пи Пи Пи буюу төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бид гаргах гэж байгаа. Үүнийг ч гэсэн түшиглээд хийчих үү гээд одооноос л бид нар энэ хуулийг хэлэлцэх явцдаа ЗГ ч гэсэн өөрийнх нь байр суурийг энэ дээр бас тодорхой болгочихвол зүгээр байгаа юм. Тэгэхээр миний асуух гээд байгаа зүйл нь яаж үүнийг санг эхний ээлжид шууд энэ хууль 23 оноос хэрэгжээд эхэлбэ гэвэл яаж бүрдүүлэх юм, юунаас эхлэх юм. Энэ ганц сан байхгүй, өөр ямар ямар эх үүсвэрээс хөгжүүлэх вэ гэдэг чухал байгаа юм. Тэгэхээр энэ мөнгө ер нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамгийн чухал зүйл нь санхүүгийн асуудал.

1 дүгээрт, Нямбаатар сайд аа, би бас хэлээд байгаа. Одоо бид жуулчид татахад хөдөө ч бай, хотод ч бай хамгийн нэг номерын асуудал, дэд бүтэц буюу 00-ийн асуудал байгаа юм. Монголд ирж байгаа жуулчид бүр бүгд ярьж байгаа шүү дээ, хамгийн хэцүү нь дэд 00-ийн асуудал Монголд байна гээд тийм ээ, Улаанбаатар хотод буугаад л буулаа, зочид буудалдаа хүртэл ер нь тэгээд л нисэх дээр ч гэсэн асуудал байдаг. Одоо тэр шинэ нисэх дээр арай өөр болсон байж байна. Аймгийн төвүүд үнэхээр их, Хэнтий, нөгөө Баян-Өлгий, Хөвсгөлд очлоо, бараг нисэх буудалд нь буухад 00 нь ажиллахгүй, ус нь байхгүй, ус

татчихсан гээд ингээд байж байна шүү дээ, яг бодит байдал. Тэгээд бид АХБ-аараа энэ 00-ийн асуудал шийдье гээд 30 сая долларын төсөл хэрэгжүүлсэн, яасан технологийг нь буруу хийсэн гээд тэр 00-ууд өнөөдөр нэг нь ч ажиллахгүй байгаа юм. Би бүр энэ Байгаль орчны сайдтай, дэд сайдын цуг хүртэл явж үзсэн. Одоо тэгээд ингээд л нөгөө нэг хөрөнгө мөнгө наад зах нь үүнээс эхлээд хэрэг болно. Эхнээсээ тэр хүмүүст ямар хариуцлага тооцох, тэр 20, 30 сая долларын 00 өнөөдөр хэрэгжээгүй, тэрийг яах вэ гэх мэтчилэн алдааг давтахгүй, харин үүнийгээ саваа бэлдэх нь их чухал байгаад байгаа юм. Яаж дэд бүтцийг нь бэлдэх вэ? Энэ халуун, хүйтэн устай 00-той байх асуудал нэг номерт байгаа. Одоо орж ирж байгаа хууль дээр яах вэ ерөнхий заалтууд байна, засаг журмаараа зохицуулах юм уу? Дэд бүтцийн энэ аль дээр надад нэг тодорхой хариулт өгөөдхөөч. Хамгийн гол нь ер нь энэ шүү, явж явж. Түүнээс биш тансаглах гэж Монголд ирдэггүй нь ойлгомжтой. Бид яаж Зүүн өмнөд Азийн орнуудтай өрсөлдөх юм тийм ээ. Энэ дээр эхлээд хариултаа авъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

**Х.Нямбаатар:** Би ч уг нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын л ажил хашиж байгаа, тэгээд яалт ч үгүй энэ хуулийн төслийг бариад яв гэсэн, тэгээд явж байна, яах вэ, тэгээд хариулна.

Энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа, дагуулаад. Тэгээд энэ ийм нэг заалт орсон юм. 15.1.15-д Аялал жуулчлалын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан аялал жуулчлалын байгууллага, отголох цэг, авто замын дагуух түр амрах газар, өөрийн ариун цэврийн байгууламжийн стандартын шаардлага хангахуйц болгож, засварласны болон стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж шинээр байгуулсны зардлыг орлогын албан татвараас шууд хасаж тооцъё гэж. Одоо энэ бол нөгөө зам дагуух бензин колонкууд энэ тэр бүгд нь ийм, идэвхжүүлэлт хийж байгаа л гэсэн нэг хэлбэр байгаа.

2 дугаарт, сая ер нь гишүүд асуугаад байна, энэ ирэх жил нөгөө аялал жуулчлалыг дэмжих сан ч нь яаж амилж явах юм бэ? нөгөө хуулиуд нь батлагдаагүй, өргөн баригдаагүй байна гэж байгаа. Өргөн баригдахын тухайд бол бид нар засаг дээр ерөнхийдөө ярьчихсан учраас энэ 7 хоногт юм уу, ирэх 7 хоногт өргөн бариад энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь шийдэгдчихвэл хамтад нь дагуулаад хэлэлцэх эсэхийг нь шийдээд тэгээд Эдийн засгийн байнгын хороо, ХЗБХ энэ тэр дээр хамтарсан ажлын хэсэг гарах байх гэж би зүгээр бодож байгаа юм. Тэгэхээр энэ казино энэ тэр дээр бол барилга байгууламжтай холбоотой учраас тодорхой хугацаа шаардагдах байх. Тендер сонгон шалгаруулалт энэ тэрийн хувьд.

Чинзориг гишүүн ээ, юуны хувьд тэр спорт бетийн тухайд бол шууд энэ нөгөө тусгай зөвшөөрөл өгч эхэлснээс хойш л нөгөө онлайн платформууд ажиллаж эхлэх учраас энэ орлого нь хэзээ зөвшөөрлөө өгнө, хэзээ хэдий богино хугацаанд өгнө, төдий чинээ хурдан хугацаанд эргээд дараагийнх нь орлогууд орж ирэх ийм боломж магадлалуудтай юм байна лээ. Юуны навигацийн орлогын тухайд бол та сая зөв хэлж байна, 120 гаран тэрбум төгрөгийн юуны навигацийн орлого олдог, үүний 20 хувь гэж бодоход нэг 30 хэдэн тэрбум төгрөгийг эхний ээлжид санд төвлөрүүлэх, энэ аялал жуулчлалын хууль маань хэзээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэх вэ. Тэр үеэс санд төвлөрүүлэх бас ийм бодит боломжууд бий гэж ойлгож болно.

Дээр нь нэг зүйлийг хэлэхэд бид нар яг ийм урамшууллыг сая өнгөрсөн жил өгсөн. Манай Их Хурлын гишүүд зарим нь мэдчихсэн байж магадгүй 1,7 тэрбум төгрөгийг 4,7 тэрбум төгрөгийг Франкфуртын чиглэлийн европ чиглэлээс ирж байгаа аялал жуулчлалыг дэмжих зорилгоор энэ 2022 оны санхүүгийн жилд МИАТ-ийн тээвэрлэгч компани, МИАТ компани санхүүгийн дэмжлэг олгож үзүүлсэн. Энэ утгаараа Франкфурт Улаанбаатар чиглэлийн нислэгийн тийзийг тодорхой түвшинд үнийг нь тогтворжуулж барьж чадсан гэдгийг бас хэлэх ёстой.

Тэгээд энэ аялал жуулчлалын хуулийн маань бас нэг том зорилго бол зөвхөн зуны 6,7, 8 сарыг аялал жуулчлалын сар гэж тодорхойлохоос илүүтэй бусад саруудыг яаж аялал жуулчлалын сар болгож, бусад саруудад яаж эвент зохион байгуулж, бусад саруудад яаж нислэгийн тийзийг хямдруулах вэ гэдэг л ийм том цогц бодлоготой байгаа л гэдгийг л хэлэх гэсэн юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Оюунчимэг гишүүн тодруулж асууя, 1 минут.

**М.Оюунчимэг:** Тэгээд хуулиа шинэчлэн найруулаад өргөн барих нэг асуудал. Хамгийн гол нь энэ хуулийг хэрэгжүүлж эхлэхэд л бүх юм гарч ирнэ шүү дээ. Тэгэхээр бид нарын яриад байгаа санхүүгийн асуудал, тэр дэд бүтэц 00, 2-т нь унаа бид нар ярьж байна шүү дээ тээвэрлэлт гээд. Нэг хэсэг үнэхээр тэр саяын миний хэлээд байгаа эдийн засгийн өсөлтийг дагаад олон авиа компаниуд чартер нислэг хийж байсан тийм ээ, Хүннү эйр, Эйр маркет, МИАТ өөрөө бас олон улсын бүр хөрөнгө оруулалттай и-би ардын ч билүү хөрөнгө оруулалттай үнэхээр үйлчлэгч тасархай, ийм нисэхүүд агаарын тээврийн компаниуд орж байсан. Харамсалтай нь дараа нь нөгөө бүх юмаа манайхан чинь үгүйсгэх хийгээд л тэр хөрөнгө оруулагчдаа хөөгөөд л дээрээс нь дотоодын ийм чартер нислэгүүд бүгд зогсоод өнөөдөр нэг хоёрхон явж байгаа. Орон нутаг руу нисэх нислэг хүндрэлтэй болчихсон. Үүнийг дагаад нөгөө орон нутгийн нисэх буудлууд нь ч унтамхай, нэг л тийм орчин нөхцөл нь ч хэцүү байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр алхам бүртээ асар их хөрөнгө шаардагдана. Тэгэхээр энэ агаарын тээврийн нислэгүүд дээр жижиг чартерын нислэг энэ тэр бий болох дээр яаж анхаарч байгаа вэ.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 2 номерыг нээх үү. 2 номерын микрофоныг нээе дээ.

**Г.Түвдэндорж:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол агаарын тээврийг либералчлалыг нь чөлөөлөх асуудлуудыг бүх хязгаарлалтуудыг авч хаяя гэж ярьж байгаа. Яг тоо хэмжээ, хүчин чадлаар нь нэг нислэгийн тоог зааж өгдөг, эсвэл нэг орны нислэгийг 7 хоногт хэдэн удаа нисэх тоог зааж өгдөг, энэ бүх хязгаарлалтуудыг тавьж чөлөөтэй тавих. Мөн чартер нислэгийн асуудлууд, бас манай 2 хөрш оронтой бас холбоотой хэлэлцээрийн асуудлууд байдаг юм байна лээ. Тэгэхээр манайх дотоодын зүгээсээ чартер нислэгийг чөлөөтэй тавьж нисэх ийм бодлого барьж байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Хариулт хангалттай юу. Оюунчимэг гишүүн хариулт хангалттай гэж үзэж байна уу. Тодруулах уу, нэмж асуух уу. Оюунчимэг гишүүнд 1 минут өгье.

**М.Оюунчимэг:** Би энэ бол асуулт асуухгүй. Зүгээр ажлын хэсгийн ахлагч маань бас сая хэлж байна. Чөлөөтэй тавих нь харин нэг хэрэг ээ, би дэд бүтэц яриад байна шүү дээ, 00 дээр ч ярьж байна, сая тэр Изнист эйр, Хүннү эйр, Эйр маркет гээд маш сайхан, ийм чартер нислэгүүд болоод авиа компаниуд байсан. Одоо ингээд бүгд ихэнх нь ажиллахгүй шүү дээ, Хүннү эйр, Эйр маркет бол хааяа нэг явж байна, тэгэхээр яаж ийм олон чартер нислэг, энэ агаарын тээврийн компаниудыг урамшуулж эд нарыг үйл ажиллагаанд оруулах, тэд нар аюулгүй буух асуудал энэ тэр гээд энэ дээр бид ийм бэлтгэлтэй байгаа, ийм дэмжлэгийг татаас маягаар үзүүлэх гэж байгаа, хуулийн шинэчлэлт энэ орж байгаа гэдэг зүйлүүдийг л уг нь асуугаад байгаа юм. Тэгээд ерөнхий хариулаад байх юм. Эхнээсээ л та нар зөв ойлголт, иргэддээ өгөх хэрэгтэй шүү дээ. Энэ чинь өөрөө ард иргэдэд, эдийн засгийн хувьд ашигтай улс оронд ийм амаргүй ковидын дараа ийм ашигтай гэдэг нь тооцоо судалгаа байж байх хэрэгтэй байхгүй юу. Угаасаа тийм их хэрэгтэй учраас оруулж ирээд байна шүү дээ. Энэ чинь их хүмүүст хэрэгтэй, манай улсад хэрэгтэй гэдгээ бид ч гэсэн бас яаравчлаад шийдье гээд л ингээд дэмжиж байна шүү дээ. Тэгэхээр асуудалдаа анхаар ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ундрам гишүүн асуулт асууя.

**Ч.Ундрам:** Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бол дэмжиж байгаа юм. Тэгэхдээ хэд хэдэн бас хэлэх зүйл асуулт байгаад байна. Монгол Улсад ерөөсөө жуулчид ирэх хамгийн гол үндсэн 2 л шалтгаан байгаа. 1-д нь бид нар бол дэлхийд давтагдашгүй түүх, соёлтой улс, 2-т нь бол мэдээж байгаль, ан амьтан гээд ийм онгон дагшин байгаль гэж хэлдэг тийм ээ. Энэ 2 зүйл л байгаад байгаа юм.

Тэгээд энэ аялал жуулчлалын хуулийг дагаж орж ирж байгаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд энэ аялал жуулчлалыг хөгжүүлэх сан гэж бий болгох гэж байна шүү дээ. Казиногийн болон энэ морин уралдааны онцгой албан татварын 5 хувиар. Үүнийгээ эргээд юунд зарцуулах юм бэ гэхээр нөгөө түүх дурсгалын эд зүйлсээ сэргээн засварлах, судлах, засаж сайжруулах юм ерөөсөө энд ороогүй. Тэгээд тэр нь болохоор Соёлын тухай хуулийн дагуу тусдаа гээд тийм юм яриад байгаатай би санал нийлэхгүй байгаад байна. Ерөөсөө энэ түүх соёл байж байж аялал жуулчлал чинь хөгжинө. Тэгэхээр энэ сангийн мөнгө тэр түүх соёлын эд зүйлс рүү бас тодорхой хэмжээгээр явах ёстой. Бид нар угаасаа соёлын салбарт олигтой төсөв тавьж чаддаггүй. Тийм учраас энэ сангаас зайлшгүй тийшээ оруулах шаардлагатай. Тэгэхээр энэ боломжийг та хэд маань судлах ёстой байх гэж бодож байна.

Агаарын тээврийг либералчилна гэдэгтэй санал нэг байна. Бас нэг судалж болох зүйл энэ МИАТ-ыг яагаад олон нийтийн компани болгож болдоггүй юм. Олон нийтийн компани болгох юм бол зардал бүх юм нь олон нийтийн хяналт дор ороод илүү сайн ашигтай ажиллах боломж нээгдэнэ гэж бодож байгаа. Тэгэхээр та хэд энэ хуулийн төслийг хэлэлцүүлэх үедээ салбарын хамт олонтой хэлэлцүүлэг хийсэн гэж би ойлгож байгаа. Тэр үед энэ асуудлыг ярьж байсан уу, үгүй юу. Энэ асуудлыг судалсан уу гэсэн асуулт байна.

Энэ бас энэ tax free тийм ээ, татварын НӨАТ-ын буцаан олголтыг 100 хувь хийнэ ээ гээд дагалдах хуулиар орж ирж байгаад бол маш талархалтай байна. Үүн дээрээс бас орлогын албан татвараас, хэрвээ ариун цэврийн байгууламж барих юм бол чөлөөлнө өө гэсэн байна. Энэ дээрээ нэмээд хог хаягдлын менежментийг оруулмаар байна. Нөгөө сайхан онгон дагшин байгаль дээр чинь очоод зөндөө хог

тариад, нөгөө үйл ажиллагаа явуулж байгаа газар нь хогоо ангилахгүй, дахин ресайкл хийхгүй, тэгээд нэг бөөн хог болсон ийм байгальтай үлдэх вий гэдэг дээр бас санаа зовж байна. Тэгэхээр хог хаягдлын менежментийг ерөөсөө бид нар орхиж болохгүй ээ. Үүнтэй холбоотой ямар нэгэн орсон зүйл байна уу.

Визний асуудлыг түрүүн яриад байна. Яг аль хууль, энэ дагалдаж орж ирж байгаа хууль дээр нь би ерөөсөө олохгүй байна, эсвэл энэ орж ирээгүй байгаа юм уу, эсвэл та хэд оруулж ирснийг нь би олохгүй байгаад байгаа юм уу. Яг аль хуулиар та хэд визний үйл ажиллагаагаа маш амархан болгох гээд байгааг ойлгохгүй байна.

Дээрээс нь энэ аялал жуулчлалын сан дээр агаарын зорчигч тээвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ ээ гэхсэн байгаа юм. Ганцхан агаараар Монгол Улсын 21 аймаг руу ганцхан агаараар нисэхгүй шүү дээ. Бас энд чинь орон нутгийн автобусны үйлчилгээнүүд байгаад байдаг. Тэгэхээр энэ автобусны үйлчилгээнүүдийг дэмжихэд чиглүүлж болохгүй юу. Тодорхой хэсгийг нь. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

**Х.Нямбаатар:** Ундрам гишүүн ээ, ер нь бол юу шүү дээ, өнөөдөр энэ нөгөө хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдэж байгаа юм. Тэгэхээр хуулийн төслийг хэлэлцэхийг шийдэхэд хуулийн төслийн зүйл заалт нэг бүрээр хэлэлцэхгүй, зөвхөн үзэл баримтлалын хувьд дэмжих эсэхийг л илэрхийлнэ. Зүйл заалт дээр хэрвээ хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн тохиолдолд саяын өөрийн чинь хэлж байгаа тэр нөгөө юуны онцгой албан, юуны Аж ахуйн нэгжийн орлогын албан атварын тухай хуульд нэмээд тэр хогны байгууламжийг ч нэмж болно, нэмээд нөгөө аялал жуулчлалыг хөгжүүлэх сан дээр соёлын асуудлыг нэмж оруулж, уг сангаас санхүүжүүлэх асуудал ч шийдэгдэж болно. Энэ бол нээлттэй асуудал. Зүгээр сая яг ингээд унших юм бол тэр ААНОАТ-ын тухай хууль дээр хогийн байгууламж, ариун цэврийн байгууламж гэдгээрээ хамтад нь л орчихсон байгаа.

Зүгээр тэр аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн 4 чиглэлд зарцуулах юман дээр яг соёлын тэр салбарын зарим барилга байгууламжуудыг сэргээн засах гэдгийг бол магадгүй нэмж оруулахыг үгүйсгэхийн аргагүй. Та гишүүний хувьд үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байгаа тохиолдолд энэ бол дараагийн хэлэлцүүлгийн шатанд нээлттэй байж болох сэдэв ээ гэж бодож байгаа.

Мөн адилхан тэр нөгөө нийтийн тээвэртэй холбоотой асуудал байгаа, тийм ээ. Жишээлэхэд, нөгөө нэг Америкт нэг ийм автомашин автобусны сүлжээ яваад байдаг. Түүнтэй адилхан манайд өнөөдрийг хүртэл санхүүгийн дэмжлэг байхгүй учраас өнөөдөр дотоодын ААН байгууллагууд БНСУ-д 7, 8 жил, 9 жил ашиглагдсан автобуснуудыг авчраад нийтийн тээвэр, хот хоорондын үйлчилгээнд ашиглаад л нэг 2 жил ажиллаад л ингээд пэнсэнд нь гаргаад байгаа юм. Гэтэл цаашаа, бид нар тийм авто машины ийм сүлжээ үүсгэж яагаад болохгүй гэж. Энэ дээр яагаад бид нар бас дэмжлэг үзүүлж болохгүй юм бэ гэдэг ийм байдлаар л хэдүүлээ энэ аялал жуулчлалын салбарыг цогцоор нь дэмжих тал дээр бол би тантай 100 хувийн санал нэг байна.

Тэгээд ер нь бид нар нөгөө сая Оюунчимэг гишүүн хэлж байна лээ. Үе үеийн ЗГ ингээд өөрсдийнхөө нөгөө доголдож байгаа зүйлүүдийг л засах гээд л хичээдэг, түүний тодорхой үр дүнгүүд гардаг. Жишээлбэл, Баяр даргын үед бүртгэлийн төгөлдөршил гэдэг л зүйл хийгдэж эхэлсэн. Өнөөдөр тэр маань улам л төгс

төгөлдөр болж, цахим тэр төрийн үйлчилгээний анхдагч суурь болж байх жишээтэй. Мөн өмнөх Батболд даргын Засгийн газрын үед энэ аялал жуулчлалыг дэмжих тодорхой бодлогууд хэрэгжээд л явж байсан. Өнөөдөр түүний үр дүнд Улаанбаатар хотод бас нэг үеэ бодвол гаднын томоохон сүлжээ ресторан, зочид буудлууд бий болж байх жишээтэй. Тэгэхээр үе үеийн Засгийн газрууд энэ дутуу зүйлээ засаж, тодорхой нэг өв үлдээх гэж л зорьж байгаагийн нэг нь энэ Монгол Улсад хамгийн ихээрээ гаднын аялал жуулчлал ирдэг л энэ эрх зүйн орчныг л бий болгох гээд байгаа юм.

Саяын би энэ Ундрам гишүүний сүүлийн асуултад хариулахад энэ эрх зүйн орчин ерөөсөө ийм байдаг юм. Нөгөө Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн Гадаад яам 2 харилцан яриад аль аль улсыг визгүй ангилал руу оруулах вэ гэдгийг Засгийн газрын тогтоолоор шийддэг. Аль алийг нь и-виз болгох вэ гэдгийг мөн тэгж шийддэг. Сая бид нар Солонгосыг хууль гаргалгүйгээр тэгээд шийдсэн. Тийм учраас Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн хүрээнд бид нар визгүй орнуудын тоог Засгийн газрын тогтоолоор Гадаад яамтай манайх тоогоо нэмэгдүүлээд баталчихна. Заримыг нь визтэй болгочихно.

Хил орчмын аялал жуулчлал дээр энэ жишээлбэл Сэлэнгэ аймгаас сонгогдсон юм уу, Өмнөговь юу гэдэг юм, Дорноговь аймгаас сонгогдсон гишүүд аягүй том боломж нээгдсэн шүү дээ. Бид нар жишээлбэл урд хөршийн бүлэг жуулчдыг хил орчимдоо 72 цаг ямар нэгэн визгүйгээр аялуулдаг эрх зүйн орчин бүрэлдээд аль хэдийн 2 жил болж байгаа юм. Яагаад үүний эффект гарахгүй байна вэ гэвэл нөгөө урд айл маань Зеро ковид гэдэг тэр юунаасаа дэглэмээ бууруулаагүй байгаа учраас хүмүүс нааш цааш нь явуулахгүй л байгаа болохоос энэ хэрвээ шийдэгдэх юм бол аягүй том эффект, магадгүй энэ аялал жуулчлалын тоо нь даблдах хүртэл тоо гарч ирнэ л гэж ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ундрам гишүүн нэмж тодруулах юм уу, нэмж тодруулах шаардлагагүй л бол Булгантуяа гишүүн асуулт асууя.

**Х.Булгантуяа:** Аялал жуулчлалын сан байгуулаад ажл жуулчлалын салбарыг ингээд бодлогоор дэмжихийг бол дэмжиж байгаа. Ийм хэдэн асуудлууд байна.

1 дүгээрт, Монголд ирсэн аялал жуулчлал энэ жуулчдаас эс үгүй бол Монголыг сонирхож байгаа хүмүүсээс та бүхэн маань судалгаа авч үзсэн үү, Яг ямар асуудлуудыг юу гэж эрэмбэлж гаргаж ирсэн бэ? 1 дүгээрт, Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариулах байх.

2 дугаарт нь, навигацийн орлогыг ирэх оны төсөв дээр 150 тэрбум төгрөг гэж тавьсан. Тэгэхдээ Монгол дээгүүр, Орос дээгүүр өнгөрч байгаа юуны нислэгийн тоо буурчхангуут Монгол дээгүүр энэ өнгөрч байгаа нислэгийн тоо бас яг буурна. Тэгэхээр ИНЕГ-аас бол 150 тэрбум төгрөгийг бид нар хийж чадах болов уу даа гэсэн айдастай байх шиг байна лээ. Тэгэхээр харин тийм, тэгэхээр та бүхэн маань энэ, тэд нар орлогыг чинь бүрдүүлэх гэж байгаа газар ийм сандарч байхад энэ орлого чинь бүрдэхгүй байх эрсдэлтэй шүү гэдгийг бас тооцож үзсэн үү.

3 дугаарт, НӨАТ-ын буцаан олголт бол аймаар шинэ зүйл бол биш, дэлхийн бүхий л улс орнуудад энэ тодорхой хэмжээгээр байдаг. Дээрээс нь нэмээд Монгол бол нэг их тийм шопингийн газар бас биш, Монголоос нэг хэдэн ноолуур л авах

байх. Тэгэхээр үүнийг бол нэг их, үүгээр бол аялал жуулчлал татна гэж бол би бол бас бодохгүй байна.

4 дүгээрт, ариун цэврийн байгууламжийн хувьд үүнийг татвараас нь юу яах биш, харин хөнгөлөлттэй зээлд ямар нэгэн байдлаар хамруулж болохгүй юу, үүнийг олон улсын байгууллагуудыг татан оролцуулж болох болов уу гэж бодож байна. Аялал жуулчлалын компаниуд аягүй хүнд 2, 3 жилийг өнгөрөөсөн учраас ахиад та нэг 100 сая төгрөг гаргаад ариун цэврийн байгууламжаа сайжруул аа гэвэл тийм мөнгөтэй ААН-үүд бол бас хэцүү байх байх гэж бодож байна.

5 дугаарт, энэ визний нөхцөлийг бас хөнгөрүүлсэн хууль, эрх зүйн орчныг Нямбаатар сайд бас оруулж ирж батлуулж чадсан. Тэгээд би бол үүнийг аягүй зөв гэж бодож байгаа юм. Миний сонссоноор хуучин Монголыг сонирхож байгаа хүмүүсийн 70 хувь нь визээ авч чаддаггүй болохоор ирдэггүй, визээ авч чадсан хүмүүсийн 70 хувь нь онгоцны билет олддоггүй болохоор ирдэггүй гэж тийм би судалгаа харж байсан. Тэгэхээр үүнтэй харьцуулах юм бол энэ бол бас ч гэж ингээд цахим визтэй болоод зарим улс орнуудыг визнээс нь хөнгөлөөд ийм нөхцөлүүд бол бас нэлээн сайжирсан.

Турист такс гэж бас нэг нэг байгаад байдаг гэж би ойлгосон, зарим улс орнуудад. Тэгээд энэ нь нөгөө нэг нислэг дээрээ биш ирчихсэн хойноо, жишээлбэл Шангри ла-д үйлчлүүлэхэд Монгол хүн миний такс нэг арай өөр, плас турист такс гэж бас нэг байдаг энэ тэр гээд тэр тухай ер нь та бүхэн судалж үзсэн үү. Тэгвэл энэ дотоод аялал жуулчлал, гадаад аялал жуулчлал гэдэг дээр бас нэг арай жоохон юу гарах юм болов уу гэж та бүхэн энэ бүгд дээр юу гэж бодож байна.

6 дугаарт, бас нэг асуудал өнгөрсөн зун Монголд ирсэн хүмүүсээс энд ирээд төлбөр тооцоогоо энэ тэр хийхэд нөгөө нэг доллар гарахгүй байна. 300 доллар гээд хязгаарлалт тавьчихаад байгаа шүү дээ. Тэгээд үүнээс үүдээд бид нарт бас их хэцүү байна гэдэг ийм асуудлыг ярьж байсан. Энэ бүгдийг ер нь та бүхэн судалж үзсэн үү. Гаднын хүн ирвэл энэ бүгд дээр нь хязгаарлалт энэ тэр хийхчээд байх юм биш биз дээ. Зөвхөн төгрөгөөр гарна, жишээлбэл доллароор хийхгүй энэ тэр гэдэг төлбөр тооцоо дээр нь ямар нэгэн байдлаар асуудал үүсэх ийм эрсдэл бидний хувьд байгаа юу гэдэг нэг ийм 6 асуудлыг асууж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгээс 2 номер хариулъя. 2 номерын микрофоныг нээе.

**Г.Түвдэндорж:** Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Ер нь Монгол Улс сүүлийн жилүүдэд ирсэн аялал жуулчлалын жуулчдаас судалгаануудыг байнга авдаг. Сүүлийн ер нь 3 жилийн судалгаанаас харахад хамгийн их хүндрэлтэй асуудал жуулчдад ерөөсөө ариун цэвэр 00-ийн ариун цэврийн байгууламжийн асуудлууд хамгийн нэгдүгээр асуудлаар гарсан.

Хоёр нь, ерөөсөө тэмдэг, тэмдэглэгээний асуудлууд замын болон гудамж чиглүүлэх, хаашаа явах, майфинг хөдөө орон нутагт явахад тэмдэг тэмдэглэгээний асуудлууд дээр маш их бэрхшээл үүсдэг гэсэн ийм судалгаанууд гарсан байж байгаа.

Ер нь аялал жуулчлалын энэ аялал жуулчлалын тухай хуулийн гол зорилго бол аялал жуулчлалын үйлдвэрлэл гэсэн энэ ангилалд дэвшүүлж аялал

жуулчлалыг үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, экспортын Монголын эдийн засагт үнэ нөлөө өгөх хамгийн чухал салбар аялал жуулчлалын салбар гэж үзээд энэ салбар дээр бэрхшээлтэй тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд аялал жуулчлалын дэд бүтэц гэдэг энэ нэр томъёогоор зам дагуух жуулчдад үзүүлэх үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах, ложистикийг сайжруулах, ариун цэврийн байгууламжуудыг сайжруулах, мөн дэлгүүр, үйлчилгээний салбаруудыг, хоол рестораны салбаруудыг сайжруулах гэдгээр энэ дэд бүтцийн аялал жуулчлалын дэд бүтэц гэдэг дээр энэ хуулийн төсөл дээр тусгаж өгсөн байж байгаа.

Мөн Аялал жуулчлалыг дэмжих сан дээр гол аялал жуулчлалыг дэмжих сангийн гол үндсэн 4 сангаас зарцуулагдах зарлага нь аялал жуулчлалын дэд бүтэц, ариун цэврийн байгууламжууд, 00-ийн асуудлуудыг шийдвэрлэх, энэ зорилгоор аялал жуулчлалын сангийн гол зорилго нь явж байгаа.

Мөн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөгжүүлэхийн тулд Монголыг сурталчлах, Монголын соёл, түүх, байгалийн үзэсгэлэнт газар энэ бүх сурталчилгааг хийх зорилгоор энэ аялал жуулчлалын сан бол өөрөө бас ажиллах ийм зорилготой байж байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе. Нэмж хариулъя.

**Х.Нямбаатар:** Тийм, ер нь саяын хэний Булган гишүүний яг хэлж байгаа саналуудыг, ер нь яг энэ хэлэлцүүлгийн шатанд бүгдийг нь л анхаарах ёстой зүйлүүд байгаа юм. Тэгээд манайх төлбөр тооцооны хувьд бол аягүй их төвөгтэй орнуудын нэг шүү дээ. Та өөрөө мэдэж байгаа, бид нарт ямархуу нөгөө гадаад гүйлгээний боломжууд байдаг вэ тийм ээ. Манай нөгөө кросспондент банкнууд юу билээ. Одоо жишээлбэл, бид нар хамгийн наад зах нь IPO юун дээр нэвтрүүлж чадаагүй байгаа шүү дээ. Тэгээд бид нарын бүх юманд хөгжилд саад болж байгаа юмнуудын дийлэнх нь л ерөөсөө энэ банк санхүүгийнхээ салбарын бас нэг ийм либералчлал. Дээр нь энэ гаднын томоохон банкнууд орж ирж байж гадаад төлбөр тооцоо клиринг дээр бид нар нэлээн давуу байдал үүсгэнэ. Манайх жишээлбэл шинэ юм биш гэж байгаа боловч ийг бид нар нэг юм хиймээр л байгаа юм.

Нарантуул чинь уг нь аягүй гоё, нөгөө нэг дундаж түүнээс доогуурх жуулчдын аягүй гоё сонирхлыг татдаг шопинг юм байна лээ шүү дээ. Тэгээд бид нар яагаад тэр Нарантуул гэдэг тэр шопингийг эргээд бид нар нөгөө юугаа tax free-тэй болгоод, тэнд худалдаа эрхлэгчидтэйгээ хамтарч ажиллаад, нөгөө юугаа биллийг нь хэвлэж өгдөг, энэ чиглэл рүү хүртэл тодорхой ажлууд хиймээр л юм байна лээ. Тэгээд бүгдэд нь нөгөө төлбөр тооцооны бүх системүүдийг ашигладаг болгох энэ зарчим руу л явчихмаар юм байна. Жоохон л хөгжүүлбэл бид нарт боломжууд байдаг. Тэгээд энэ удаа Аялал жуулчлалын тухай хуулийн маань хамгийн том урдаа барьж байгаа, өмнөө барьж байгаа том зорилго бол бид эхлээд заавал ирүүлэх гээд оролдоод үзье ээ. Сая түүнээс дээш жуулчдыг ирүүлэх гээд оролдоод үзье. Ирсэн хойно нь аятай байлгах асуудлыг яамнаасаа тусгай зөвшөөрөл авсан нөгөө Тур операторууд нь үзэг, бүх юм хаалттай, далд байдгийг нь больё.

Аргал агная гэж байгаа хүмүүсийг Тур операторууд нь дуудлага худалдаагаар ил яагаад, тэгээд тэр газар нь очиж аялал жуулчлал хийлгэе. Тэгэхгүй одоогийн байгаа нэг заваан тогтолцоо нь заавал нэг отог гэдэг юман дээр давхар нөгөө юуны тусгай зөвшөөрлийнх нь юу зөвшөөрөл нь тусад нь гарч ирдэг.

Яагаад өнөөдөр хүн 100 сая төгрөгөөр 10 аргал агнуулна гээд тэрбум төгрөг тушаачихсан Тур оператор тэр газар нь очоод заавал агнуулж л таараа байхгүй юу. Заавал нэг илүү дамжлага дамжмааргүй байна. Тэр нөгөө нэг шонхрын ан яриад л байдаг, шонхрыг яриад л байдаг, ямар зарчмаар энэ сүүлийн 20, 30 жил хэнд өгөгдсөн юм мэддэггүй шүү дээ, бид нар мэддэггүй. Тэрийг яагаад өнөөдөр Тур операторууд яг тэр булангийн орнуудаас үнэтэй жуулчдыг авчраад тэдэн сарын тэдний өдөр Монгол Улсын Засгийн газар тэдэн ширхэг шонхор худалдана, тэд нь эр, тэд нь нэм гээд дуудлага худалдааны тийм зорилтот аялал жуулчлал хийгээд байж болохгүй юм бэ гэдэг ийм агуулгаар л энэ удаагийн Аялал жуулчлалын тухай хуулийг оруулж ирж байгаа юм.

Цаг хугацааны хувьд нэлээн тулгуу шахуу байсан. Энэ дээр суусан 2 яам, бусад яамдын төлөөллүүд энд байж байна. Би мэдээж хэрэг бүх салбарын юмыг сайн мэдэхгүй учраас дутуу дулимаг ярьж байгаа байх. Жишээлбэл, тэр хувийн үгүй ээ, дотоодын нислэгийг нэмэгдүүлье гээд Бямбацогт сайд бол энэ дээр бүр аягүй их том акцент өгч байгаа юм. Бямбацогт сайд юу гэж уурлаж байгаа вэ гэвэл гадаад нислэг, дотоод нислэг 2 дээр яг адилхан зорчигчийнх нь тоогоор татаас өгч байж энэ алсын аймгууд, тэгээд дундын зайн нислэгүүд сэргэнэ ээ. Жишээлбэл, юу гэдэг юм Өвөрхангай аймгийн төв рүү нисдэг нислэг сэргэх ёстой, Дорнод аймгийн нислэг сэргэх ёстой, Өмнөговь аймгийн Даланзадгад руу нисдэг нислэгүүдийн давтамж нэмэгдэх ёстой гэдэг ийм л байр суурийг илэрхийлж байгаа юм.

Тэгэхээр энэ бол нэг зүгээр өнцгөөр биш, Оюунаа гишүүний саяын хэлж байгаа тэр ариун цэврийн байгууламж гэдэг дээр сая өөрийн чинь хэлж байгаа тэр юун дээр бид нар яг энэ хэлэлцүүлгийн шатанд Засгийн газарт нэмэлт үүрэг даалгаврыг өгөх хэрэгтэй л дээ. Өөрөөр хэлбэл энэ салбарыг татварын бодлогоос дэмжихээс гадна ариун цэврийн байгууламж, ариутгах татуургыг хийвэл хөнгөлөлттэй зээлийг ЗГ энэ сангаас бас давхар олгоно гэдэг ийм дэмжлэг байхад л энэ бол ингээд л өөрөө бас явчихна л гэсэн санаа хэлэх гэсэн юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Булгантуяа гишүүн тодруулж асууя, 1 минут.

**Х.Булгантуяа:** Бид нар яг энэ төлбөр тооцоон дээр бол, хэрвээ мөнгө үрүүлбэ гэж бодож байгаа бол үүнийг бол бид нар зайлшгүй хийх ёстой. Тэгээд үүн дээр та бүхэн маань нэг бүр ажлын нэг энэ аялал жуулчлалыг татах нэг ажлын нэг том хэсэг болгож оруулж ирээрэй. Энд ирээд мөнгөө үрж чадахгүй хүмүүст бид нар Нөат-ын буцаан олголт гэж яриад бол хэрэг байхгүй шүү дээ. Тэгэхээр үүн дээр та бүхэн маань манай Монголбанкинд үүрэг чиглэл өгөөд үүн дээр бүр ажил хэрэг болгоорой.

Тэгээд бид өмнө нь бас энэ бүлгийн хурал дээр ч гэсэн бас хэлж байсан. Бид нар 21 аймгийг 2023 онд бүгдээрэнг нь аялал жуулчлалын аймаг болгож чадахгүй байх аа. Тэгэхээр бүр жишиг болгоод жуулчдын 60 хувь нь Өмнөговь явдаг гэсэн. Тэгэхээр Өмнөговь аймаг, Хөвсгөл аймаг, Архангай, Өвөрхангай бас байдаг, ингээд дээрээс нь нэмээд Хэнтий аймаг гээд энэ нөгөө онгоцны буудалтай болж байгаа учраас олон улсын хэмжээний, тэгэхээр эдгээр аймгуудыгаа эхний шатанд барьж аваад бүр яг маршрутыг нь гаргаад, ерөөсөө аялал жуулчлалын нэг пакеж гаргаад та, гадаад хүн үнэнийг хэлэхэд Монгол ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд үг хэлэх гишүүд байна уу. Булгантуяа, Бат-Эрдэнэ гишүүн, би сүүлд нь хэлье, ингээд тасалъя. Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Булгантуяа гишүүний микрофоныг нээе.

**Х.Булгантуяа:** Би тэгээд зүгээр тэгж хэлэх гэсэн юм. 2023 онд хэдүүлээ 3, 4 аймгийг барьж аваад жишиг болгоод л бүх ариун цэврийн байгууламжуудыг нь сайжруулаад, тэнд байгаа кампуудыг нь сайжруулаад, тийшээ бүх гадаадаас ирж байгаа жуулчдыг пакеж болгоод л зардаг юм байна лээ. Та ерөөсөө энд бууна, ийшээ ниснэ, энд хоол иднэ, ийм юм үзнэ, ийм бид нар дэлгүүрээр оруулна гээд. Монголын үнэнийг хэлэхэд ирэх гэж байгаа газруудынхаа нэрийг ч хэлж чаддаггүй юм. Тэгэхээр тэнд энд ирээд л өөрсдөө маршрутаа зохиогоод гэж хэзээ ч байхгүй учраас маршрутыг нь зохиолгоод тэгээд л түүнийг нь олон улсын энэ Тур компаниудаар заруулах энэ ажлуудыг нь хийгээд, харин 23 онд ирэх гэж байгаа компаниудын ирж байгаа хүмүүстээ сайхан сэтгэгдэлтэй буцааж явуулахын тулд энэ маршрутыг нь л засаад өгчих. Түүнээс биш 21 аймгийг бид нар барахгүй. Бид нар үнэнийг хэлэхэд 100 тэрбумаар мөнгийг нь бэлэн байж байхад чинь хэдэн сургуулийнхаа хөдөө орон нутгийнхаа хэдэн сургуулийн 00-ийн асуудлыг шийдэж чадахгүй байна шүү дээ. Технологи нь тодорхойгүй байгаад байна, ийм байна, тийм байна гээд. Тэгэхээр энэ олон аялал жуулчлалын баазуудыг өнөөдөр та бүхэн өөрсдөө мөнгөө гарга гэсэн ч одоохондоо чадахгүй. Тэгэхээр үүнийг бол зээлээр 1 дүгээрт, хийх нь бол зүйтэй.

2 дугаарт, энэ жуулчдаа бас нэг та бүхэн маань аягүй сайн ангилаач. Тэгэхгүй бол ингээд л нэг бараг тэрбум төгрөгөөр ан хийх гэж байгаа хүнтэй ингээд л яг нийлүүлээд л яг адилхан авч үзээд л мөнгөө үрж ирж байгаа, жилд нэг аравхан хоногийн амралт олдож байгаа жуулчин гэдэг хүн бол тэр 10 хоног аймаар хайран байхгүй юу.

Тэгээд үнэнийг хэлэхэд та бүхэн бас ингэж бодоод байх юм. Нэг Даланзадгад руу нэг 5 цаг, 6 цаг машинаар явах газар луу манай нисэх онгоцны буудал руу нэг талдаа 2 цаг түгжрээд тэнд очоод 1 цаг гаруй нисээд ингэж явах уу, үгүй юу. Магадгүй тэр хүн бараг замдаа юм үзээд машинаар явъя гэж байж магадгүй. Тэгэхээр энэ бүгдийг бид нар нэгэнт нисэх онгоцны буудал маань ийм хүнд болчихсон, ийм хол болчихсон байгаа цагт үүнийг бас яаж хийх вэ? Тэгээд нисэх онгоцныхоо буудалтай ойрхон нэн түрүүнд нэг юу бариач ээ, буудал бариач ээ. Онгоцны буудлаас л наашаа Улаанбаатар хот нэг их үзэхээр гоё хот биш байхгүй юу. Тэгэхээр ийшээ магадгүй нэг талдаа л ирэх гэж үзэх байх, ирэхдээ эсвэл нэг үзчихээд л тэгээд яваад өгөх байх. Тэгээд энэ бүх юмнуудаа нэг бүр нэг сайн та бүхэн маань бодоод, тэгээд миний бодлоор зүгээр ингэмээр санагдах юм. Бид нар өнөөдрийг болтол энэ жуулчдыг сайн татаж чадаагүй юм чинь зүгээр нэг мундаг гаднын зөвлөх авчирч ирээд л Та гадаад хүний нүдээр хараад өгөөч. Магадгүй 1 ази, 1 европ тийм ээ, хүн ийм жуулчны ийм зөвлөх компаниуд гэж байдаг гэсэн зөвлөхүүд байдаг гэсэн. Тэд нарыг авчирч ирээд л цагаан хүний нүдээр харахад Монгол бэлгийг яамаар байна. Ази хүний хүмүүсийг татахад яамаар байна гээд л нэг 2, 3 тийм мундаг зөвлөхүүдтэй хамтран ажиллаад 23 онд тэглэвэл үр дүн гарах байх. Хэдүүлээ үүнийг ярьж тойрч суугаад суугаад, магадгүй төдийлөн сайн үр дүн гарахгүй болов уу л гэж бодож байна.

Тэгээд бас та бүхэн маань уриан дээрээ бас дахиж нэг бодоорой. welcome гэдэг бол одоо ч манай Буянт-Ухаа нисэх онгоцны буудлын үүдэн дээр welcome to Mongolia гээд л байж л байгаа. Үүнийг байлаа гээд Монгол руу аялал жуулчлал

нэмэгдээгүй шүү. Тэгэхээр харин юу байх ёстой юм. Түүнийгээ та бүхэн маань бас нэг арай өөр байдлаар ашиглаарай.

Эцэс сүүлд нь энэ Инстаграм энэ тэрээр сүүлийн үед аягүй их туризмын пиар хийдэг болчихжээ. Та бүхэн харсан уу, үгүй юу. Энэ нэг соёлын Монголд бол юу хийх, юу үзэх юм бэ гээд ингээд манай хүмүүс асуугаад байгаа. Монголд юу үзэх вэ гэхээр шүү дээ тийм ээ, Монголын нэг соёлыг үзнэ, байгалийг үзнэ. Монголыг яагаад вэ гэвэл өнөөдрийг болтол 1 онгон дагшин байгальтай, ард түмэн нэг сайхан сэтгэлтэй тийм хүмүүс байдаг гэсэн очиж үзэх юм сан, тийм ээ нэг хөгжил цэцэглэлт гар хүрээд уул уурхай хамаг юмаа ухуулахаас нь өмнө очиж үзэх юм сан л гэж бодож байгаа юм. Бид нар бол түүнээс энд ирээд л аймаар том байшин, хөшөө дурсгал тэд нарт ерөөсөө сонин биш, түүнээс гоё юмнууд эдгээр улс орнууд байгаа байхгүй юу. Тэгэхээр харин үүнийг ээ хэдүүлээ бүр л нэг гоё маршрутыг нь л бэлдээд л, бэлэн маршрут л зарах дээр та бүхэн маань олон улсын компаниудтай хамтарч ажиллаарай л гэж л зөвлөх гэсэн юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Булгантуяа гишүүний үгэн дээр нэмээд хэлчихмээр санагдлаа. Харин та Булганыг яагаад хэлсэнгүй вэ л гэж бодлоо. Та нар амарч зугаалахаараа болохоор гайхамшигтай сайхан байгальтай гээд л магтаад байдаг юм байна лээ. Тэгээд энэ индрийн ар дээрээс болохоор ерөөсөө дуугарахгүй юм. Тэгэхдээ би тэрийг хэлэх гээгүй л дээ, тийм, би тэрийг хэлэх гээгүй ээ.

Ер нь наашаагаа аялж жуулчлахад гайхалтай сайхан юм үзэх гэж ирээгүй шүү дээ. Гайхалтай сайхан байшин барилга юу гэдэг юм соёл үзэх гээгүй байхгүй юу. Тэр чинь өөрсдөө тийм соёлтой, өөрийн гэсэн соёлтой, өөрийн гэсэн хөгжилтэй ийм газраас ирж байгаа. Монгол Улсыг сонирхож л ирж байгаа шүү дээ. Нэг судалгаа хийсэн, тэр судалгаагаар юу гарсан бэ гэхээр Монгол Улс гэж юу байна гээд, тэгэхээр зүгээр нэг гэр гарч ирсэн, байгаль гарч ирсэн, Чингис хааны зураг гарч байсан, энэ 3 зүйл гарч ирсэн л гээд байгаа судалгаагаар. Тэгэхээр үндсэндээ Монгол Улс танигдаагүй улс. Тэгэхээр наашаагаа ирэх хаалгыг л зүгээр нээх ёстой юм байгаад байгаа юм. Үүнийг нээхийн тулд юу, аялал жуулчлалын сая хэллээ, тэр пакеж юунууд гаргаж ирж, ямар аялал жуулчлал байх юм гэдгийг нь нэг тодорхойлчихоод, 2 дугаарт наашаа ирэх тээврийн зардал чинь л хамгийн хямд л байх ёстой. Хамгийн сонирхол татах хүний энгийн асуудал санхүүгийн асуудал шүү дээ. Тэр нь л энгийн байх ёстой. Тэгээд нэг хүрч ирчхээд, 2 ирээд таалагдаад дараагийн таалагдах асуудал нь 2 дахь асуудал. Яг юу үзүүлэх вэ. Ямар хүндрэлүүд байлгах юм, ямар хүндрэлүүдийг нь арилгах юм, яаж дараагийн хүн давтаж наашаа ирэх ёстой юм. Энэ бол дараагийн асуудал байхгүй юу даа.

Тэгээд ерөөсөө наашаа Монгол руу шуурдаг, Монгол руу орох л асуудал. Сая хэллээ шүү дээ, Welcome to Mongolia гээд тэгж хэлснээр бид нар наашаагаа шуурна гэж байхгүй байхгүй юу даа.

2 дугаарт, энэ үгнийхээ асуудлуудыг бас эргэж нэг хараарай гэж хэлмээр байна. Яг л санал нэгтэй байна. Тэгээд хамгийн дахиад буцаад хэлэхэд ерөөсөө л санхүүгийн наашаагаа аялал жуулчлал урсгах асуудал чинь ерөөсөө л санхүүгийн асуудал, тэрийгээ нээчих л дээ, нээчих. Түүн дээр хамаг ач холбогдлоо л өгчихмөөр байна шүү дээ, ерөөсөө. Тэгээд хүрч ирэх дараагийн асуудлууд нь юу байх юм, визний асуудал нэгдүгээр номерт байна гэсэн, 2 дугаарт, тээврийн

асуудал байна гэсэн үнэ билетийн үнэ, тикитний үнэ ямар байх юм гэдэг асуудал байна гэсэн.

Тэгээд түүний ар талд нь юу үзэх юм, яах юм, юугаа сайжруулах юм энэ хоёрхон жилийн дотор 3 жилийн дотор бид нар бүх асуудлуудаа шийдвэрлүүлээд л үзэх харах юмнуудыг нь хөгжүүлээд л, тэднийг дуурайсан, тэдэнд үзүүлэхээр гоё байшин барилга бас бариад л, зам харгуу засаад ингээд л ийм хөрөнгө оруулалтуудыг хийж чадахгүй. Сая буудал бариач ээ л гэж байна. Буудал барихаар байсан зөндөө буудлыг энд тэнд бид нар барьчих л байсан, барьдаг хөрөнгө гэж хаана байгаа билээ. Тэрийг хэмжээнд энэ Тур операторууд, аялал жуулчлалынхан чинь тэр хэмжээнд хөл дээрээ хөрөнгөө хөл дээрээ босоцгоосон, хөрөнгөжсөн юм уу, үгүй юм уу гэдэг асуудал чинь дараагийн асуудал болчхож байна. Тэр хэмжээнд хэрвээ чаддаг л байсан бол бид нар өчнөөн олон сайхан гайхамшигтай буудал сав бариад л ингээд явчих л байсан шүү дээ.

Ирэх тусам энэ орлого чинь бий болоод, ирэх тусам энэ хүмүүс чинь өөрсдөө өөр дээрээ хөрөнгө бий болоод хөгжөөд ингээд яваад байх ёстой шүү дээ. Тийм болохоор ерөөсөө л хаалгаа хамгийн түрүүнд нээх асуудал байхгүй юу даа. Одоо ингээд та бүхний хариулж байгаа хариулт дотроос чинь хамгийн түрүүнд тэр судалгаануудаа яримаар байна шүү дээ. Ийм ийм ийм учраас бид нар ингээд энэ судалгаагаа үндэслээд энэ зүйлийг хийж байгаа юм. Энэ санг бий болгож байгаа юм. Энэ тээврийн асуудлуудыг буулгаж байгаа юм. Үнэхээр үүний чиглэлээр ажиллаж л байгаа үүгээр мэргэшиж л байгаа бол та нар хамгийн түрүүнд энэ судалгаагаа ярьж байх хэрэгтэй байна шүү дээ. Энэ судалгаа чинь та нарт байх ёстой байхгүй юу даа. Тэгээд үүнийгээ ярихгүй болохоор гишүүддээ хөтлөгдөөд тэгээд нэг мэдэхэд харж байгаарай, наад юу чинь хууль чинь нэг мэдсэн чинь шал ондоо тийшээгээ хувираад л, хэдэн тийшээгээ татаж чангаагаад л сая хүртэл хэлж байгаа, Булган, Булган гэж байгаа гээд тэгэнгүүт миний өвчин хөдлөөд Булган гэж дотор нь нэр оруулаад л ингээд л явна шүү дээ, аягүй бол. Үнэн биз дээ.

Тэгэхээр ерөөсөө өөрсдийнхөө концепцыг хараад байгаа нь ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Оюунчимэг гишүүн саналаа хэлье.

**М.Оюунчимэг:** Тэгэхээр нөгөө анхнаасаа зөв мессеж өгөөд, тэгээд энэ хуулиа гаргаад хэрэгжүүлээд явах нь бол зүйтэй байгаа. Тэгэхээр би бас яг түрүүний гишүүдийн адил бүлгийн хурал дээр ч хэлж байсан. Энэ уриа бол биш байна тийм ээ, welcome гэдэг чинь бүх улс руу ороход л тэгж байдаг шүү дээ, угаасаа л тавтай морилоорой л гээд л хэлдэг.

Харин жишээ нь спайрм Малайзи гэдэг юм уу. Одоо Хакүхо аваргын тоглосон тэр видеог үзэхэд энэ үг жишээ нь зохицохгүй байгаа байхгүй юу. Шал өөр байна лээ шүү дээ, тэр гоё. Тэгэхээр үүнийг ингээд яаж засаг дээр энэ дээрээ тохирчихсон гээд яриад байх юм. Үүнийг бол өөрчлөх хэрэгтэй тийм ээ. Энэ үнэхээр өөр юугаараа өөр байдаг юм. Магадгүй тэр сая хэлээд байгаа Энержи айзин ч гэдэг юм уу тийм ээ, өөр юмнуудыг жоохон өөрчлөхгүй бол энэ нэр дээр бол биш байна гэдгийг хэлье.

Хоёрт нь, бид нар бас зорилго тавих хэрэгтэй л дээ. Европын орон аялал жуулчлал өндөр хөгжсөн орнуудаас бид жуулчдыг нааш нь татна гэдэг бол жишээ нь бага шүү дээ. Гэхдээ өмнө нь тэр аялал жуулчлалын хууль юм уу аялал

жуулчлалын тухай аялал жуулчлалын яамныхан орж ирэхдээ бидний нэг номерын зорилго бол Зүүн өмнөд Ази 2 хөршөө их илүү татаж байж, тэгээд тэндээсээ аялал жуулчлалаа илүү хөгжүүлэе гээд ярьж байгаа. Тэгээд Нямбаатар сайд хэлээд байна лээ л дээ, хамгийн гол нь хямд байх, хямд өртгийн тухай асуудал ярьж байгаа гээд. Зүүн өмнөд Азийн орнууд, жишээлбэл ковидын өмнө тэр улс руу аялахад бараг 300, 400 доллар тасархай сайхан аялчхаад ирдэг гээд ярьдаг шүү дээ. Гэтэл манайд тэд нараас хямд байж чадах уу, тийшээ чиглэдэг жуулчдыг бид татаж чадах уу, чадна гэж зорилго тавих нь чухал, татахын тулд яах вэ гэдэг асуудал өөрөө чухал. Тэдэнтэй үнээр өрсөлдөнө, дээрээс нь энэ улсууд чинь өөрөө аялал жуулчлал хөгжихсөн улсууд. Казино нь ч бас байж байна тийм ээ. Тэгэхээр бид нар яаж энэ жуулчдыг тэндээс татах вэ, бидний жуулчид хэн байх вэ, аль жуулчлалыг илүү хөгжүүлэх вэ гэдэг энэ тэр зорилтоо бид бас энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлэх дээрээ давхар цогцоор асуудлыг шийдэхдээ анхаараад явчих нь зөв байгаа шүү. Тэгээд ажлын хэсгийнхэн бас их итгэл үнэмшилтэй энэ дээрээ байх хэрэгтэй байна.

Манай Түвдээ дарга чинь төсөв мөнгийг бол ёстой мундаг ярьдаг хүн шүү дээ. Энэ аялал жуулчлалын энэ ажлын хэсгийн ахлагч юм шиг байна. Тэгээд энэ дэд юу, яамныхнаа энэ минь дээр илүү сайн, бас нэг мэргэжлийн хүмүүстэй ажиллах хэрэгтэй байх шүү гэж хэлье.

**Ц.Цэрэнпунцаг:** Чинзориг гишүүн санал хэлье.

**С.Чинзориг:** Тэгсэн юм уу, тэгвэл больдог юм уу. Тэгэхээр яах вэ, ингээд анхны хэлэлцүүлэг хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд тэгээд анхны хэлэлцүүлэгт бэлтгэхдээ ажлын хэсэг бас гараад нэлээн сайн ярина биз дээ. Би энэ 2, 3 санал бол байгаа юм.

Өчигдөр Нямбаатар сайд бүлэг дээр ярихдаа би буруу ойлгочихсон уу. Аялал жуулчлалын маршрутыг бид тогтоохгүй гээд байгаа юм, орон нутаг тогтооно гээд хэлнэ лээ дээ. Би эсрэг саналтай байгаа юм. Яг аялал жуулчлалын маршрутыг бол аялал жуулчлалн яам нь байдаг юм уу, хэн нь байдаг юм, тогтоох хэрэгтэй шүү дээ. Тэр зүүн бүсэд юу үзүүлэх юм, говийн бүсэд нь юу үзүүлэх юм, хангайн бүсэд нь юу үзүүлэх юм, ямар машинуудтай байх юм. Дунд нь нөгөө тоглох газар нь ямар юм байх юм, ямар юм үзээд, тэгээд хаана очоод хоол идэж байх юм гээд. Энэ маршрутыг бол төв засгаасаа ч юм уу тогтоодог байх нь зүйтэй болов уу. Би бол тийм бодолтой байгаа юм.

2 дахь асуудал нь, тэгээд концепц дээрээ жоохон анхаармаар л яг одоо Монголчууд, Монголд ирж байгаа аялал жуулчлал яг юу үзэх юм бэ, юу бид юу үзүүлэх юм бэ гэдгийг л маш сайн тодорхойлмоор байна шүү дээ. Тэгэхээр бол 5.1 дээр чинь тэр стандарт үйлчилгээг бид заачихсан л гээд байгаа юм. Яах вэ тэр бол тэр буудал дээр ер нь байдаг л юм байгаа биз. Монголд ирж байгаа аялал жуулчлал яг юу хийж үзэх гэж ирж байгаа юм, бид нар юу үзүүлэх юм гэдэг юмаа л нэлээн сайн тодорхой болгомоор байна, би бол.

3 дахь юм нь, тэр агаарын тээвэрт дэмжлэг үзүүлнэ гэдэг асуудлыг яах вэ, анхны хэлэлцүүлэг дээр нь л ярих байлгүй дээ. Би бол эхний ээлжид ядаж үндэсний авиа компаниа дэмжих чиглэлээр дэмжлэг байх нь зүйтэй болов уу л гэж би бодож байна. Одоо сайд нь байсан манай Бат-Эрдэнэ бол гэж мэдэж л байгаа шүү дээ. Солонгосын авиа компаниуд хамаг нислэгийг нь авчихаар манай МИАТ чинь нислэг олдохгүй маш хүнд байдалтай байдаг шүү дээ. Тэгэхээр энэ олон

улсын авиа компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ ээ гэвэл манай үндэсний МИАТ компани чинь бүр үйл ажиллагаа нь зогсчих вий дээ. Би бол эхний ээлжид дотоодын авиа компанийг дэмжих чиглэлээр байх нь зүйтэй болов уу л гэж бодож байгаа юм. Үүнийг бол анхны хэлэлцүүлэг дээр бол нэлээн сайн ярина биз.

2 дахь асуудал нь, тэр Ундрам гишүүнтэй ч би санал нэг байгаа юм. Тэр сангийн зарцуулалт дээр гол нь энэ ариун дагшин байгалийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр сангийн бас хөрөнгийг зарцуулдаг байх чиглэлийн юм оруулмаар байгаа юм. 2 дахь нь тэр түүх соёлын дурсгалт газруудыг тохижуулах, сэргээн засварлах асуудлыг бас тэр сангийн юманд оруулмаар байгаа юм. Одоогийн хуулиар соёлын тухай хуулиараа зохицуулна гээд л байгаа юм, ерөөсөө мөнгө олддоггүй шүү дээ. Манайх чинь Хархорум гэхэд л тэр Эрдэнэзуугийн нөгөө суваргуудыг засах гээд л мөнгө олддоггүй, нэлээн л юм хэрүүл болж байж нэг ганц нэг дуганаар нь, ганц нэг баганаар нь засдаг шүү дээ. Ийм чиглэлийн юмыг тэр сангийн юманд нь оруулж өгмөөр бол байгаа юм.

2 дахь юм нь, энэ аялал жуулчлал чинь бол ер нь болбол, цаашдаа бол ер нь бол бизнес шүү дээ. Аялал жуулчлалын үйлчилгээ явуулж байгаа компаниуд яг юугаа хариуцах юм бэ гэдгийг бас нэлээн сайн яримаар байгаа юм. Тэгэхгүй бол бид чинь ингээд агаарын тээврийн санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэж байна, тэгээд л бүх л тэр ариун цэврийн байгууламжийг нь засаг хийгээд өгнө, сангаас хийгээд өгнө л гээд байх юм. Яг тэр аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд чинь өөрсдөө юу хариуцах юм, ямар хариуцлага байх юм гэдгийг нь нэлээн сайн үүрэгжүүлж өгмөөр байгаа юм. Тэгээд гол ашгийг нь тэд нар чинь л хүртэнэ биз дээ. Тийм учраас бүх юмыг нь ... /минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ерөнхийдөө энэ хуулийг бол үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаа. Тэгээд ер нь хамгийн гол хуулийн гишүүдийн анхаарч, бас хамгийн гол нь санаа зовж яриад байгаа юм бол нэг сан гэж нэг юм байгуулчихаад л түүнээс нь сангуудаас чинь бид нар бүр бүр айдастай болсон шүү дээ. 1 сан байгуулж байгаад л тэгээд л түүнийг нь одоо, тэгээд ялангуяа тэр зориулалтынх нь 4 чиглэлээр зориулалттай гэж байна.

Булгантуяа гишүүн ээ, одоо санал хураана шүү.

4 зориулалтынх нь нэг нь бол тэр дэд бүтэц гээд аягүй ерөнхий юм тавьчихсан. Тэр дэд бүтцэд нь юу юу ороод байгаа юм, ариун цэврийн байгууламж нь ороод байгаа юм уу, юу нь ороод байгаа юм гээд энэ нэг иймэрхүү юм байна шүү. Үүнийгээ үзэхээр цаашдаа хуулиа хэлэлцээд явахдаа хууль дээр ажиллахдаа анхаарч үзнэ биз дээ.

Хамгийн гол нь ирэх жуулчлал, энэ хууль гарсны үр дүн бол юугаар үнэлэгдэх юм гэхээр зэрэг тоогоор үнэлэгдэхгүй ээ. Яах вэ, тоо бол мэдээж нэг үзүүлэлт нь. Хамгийн гол үзүүлэлт бол бид нар эндээс энэ Монгол Улс ямар эдийн засгийн үр өгөөж авч үлдсэн юм гэдэг юм л хамгийн гол агуулга нь шүү дээ. Тэгэхдээ бид нар бол цаашдаа энэ хуулийн гол зорилго бол аль болохоор энд гайгүй шиг мөнгөө Монголд шингээх үлдээх л ийм л жуулчдыг зорьж, энэ хууль бол энэ рүү чиглэгдэх ёстой шүү. Энэ дээр сайн та бүхэн анхаарч аль болохоор зэрэг гайгүй мөнгө төлдөг, тэр өндөр зэрэглэлтэй тэр чиглэлийнх нь жуулчдыг бид нар татах арга хэмжээ болох ёстой.

Ер нь тэр энэ сангаас зарцуулах мөнгө гэхээр зэрэг нөгөө л төсвийн мөнгийг энэ татвар төлөгчдийн мөнгийг аваачиж баахан хувийн хэвшлийнхэнд тараах асуудал байна гэж гишүүд бас санаа зовж байна шүү. Энэ бол ер нь татвар төлөгчдийн мөнгө бол хувийн хэвшлийнхэн хөрөнгө оруулалтаа хийх тэр эхний хөрөнгө л болж, одоо жишээлбэл талх барихад нэг хөрөнгө ашигладаг шиг үүсгэгч ашигладаг шиг энэ хөрөнгө болгож л өгөх зориулалтаар эхлэх болохоос биш тэр дэд бүтцийг нь байгуулаад тэр бүх хөрөнгө оруулалтын гээд л санхүүжилтийг нь хийгээд явах мөнгө биш шүү. Үүнийг сайн ойлгож та бүхэн энэ хууль дээрээ ажиллах хэрэгтэй шүү. Ийм байна.

Ингээд дэмжиж байгаа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Санал хураалт явуулж эхэлье.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хурааж явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 63,66 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын. Их Хурлын гишүүн Оюунчимэг танилцуулна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Гишүүдэд анхааруулж хэлэхэд ажлын хэсэгт орох гишүүд нэрсээ өгөөрэй, нэрийг нь аваарай, энд.

Ингээд гишүүддээ баярлалаа.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА